

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр -13
Шөнө -22

ОНЦЛОХ ХУУДАС

ТӨРД АЖИЛЛАСАН
ТУРШЛАГАТАЙ САЙД

V нүүрт

ЧУХАА
ХҮН

П.МӨНХЧУЛУУН: МОНГОЛ УЛС ЭДИЙН
ЗАСГИЙН ДАЙНД ЯЛАГДСАН УЧРААС АРД
ИРГЭД БООЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙНА

VI-VII нүүрт

Дугаарын 60 мөр

ҮЗЭЛ БОДОЛ

АН 5 ХУВААГДАХ ВИЙ ДЭЭ

Хөшигийн хөндийн
нисэх онгоцны
буудал дэлхийн
жишигт нийцэх үү
Н.ПУНЦАГ

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Хөшигийн хөндийд Олон улсын нисэх онгоцны буудал баригдаж байгаа билээ. Төлөвлөгөө ёсоор бол энэ нисэх буудал өдийд ашиглалтад орж байх ёстой. Учир нь өнгөрсөн жилийн тавдугаар сарын 23-нд тэр үед УИХ-ын дарга байсан З.Энхболд Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудлын ажиглалт танилцсан. Тэр үед хэрвээ одоогийн хурдаараа ажиллавал 2016 оны арванхоёрдугаар сард дуусгана гэж гүйцэтгэгчид нь ярьж байсан. Тэгэхээр юу юугүй ашиглалтад орох дөхчихсөн байсан гэсэн үг.

Үргэлжлэл нь III нүүрт



Үргэлжлэл нь III нүүрт

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

САЙД ЯРЬЖ БАЙНА

Д.ОЮУНХОРОЛ: Түүхий нүүрсний хэрэглээг нийслэлд хязгаарлах ёстой



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Агаарын бохирдлыг бууруулах талаар барьж буй бодлого, шийдвэрийн талаар БОАЖ-ын сайд, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны дэд дарга Д.Оюунхоролтой ярилцлаа.

-Цаг үеийн хамгийн чухал сэдэв агаарын бохирдолтой тэмцэх асуудал. НҮБ-аас ийм хэмжээний агаарын бохирдол үзээгүй гэж мэдэгдсэн. Мөн хэвлэл мэдээллээр төрөл бүрийн судалгааны дүн гарч байна. Салбарын яамны сайдын

хувьд агаарын бохирдлын өнөөгийн нөхцөл байдал ямар хэмжээнд байгааг хэлж өгнө үү?

-Агаарын чанарын албанаас гаргасан судалгаагаар Улаанбаатар хотын агаарын бохирдлын хэмжээ байх ёстой стандартаас 10 гаруй хувиар

давсан үзүүлэлттэй гарч байгаа нь хүний эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж байна. Улаанбаатар хотын хэмжээнд амьсгалын замын эрхтний өвчлөл жил дараалан өсч байгаа мэдээ гарсан.

Үргэлжлэл нь IV нүүрт

ДОТОР НҮҮРТ



ХЯТАДАД ГАДАА
ШАЛГАЛТ АВСАН
БАГШИЙГ
АЖЛААС НЬ
ХАЛЖ БАЙНА

9

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААН

БОАЖЯ, МУИС хамтран зохион байгуулж байгаа "Нийгэм эдийн засгийн хөгжилд байгалийн нөхцөл, нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан үзэх нь" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын хүрээнд гэрэл зураг сонирхогчдын дунд Монгол орны байгалийн үзэсгэлэн, өвөрмөц онцлогийн чиглэлээр гэрэл зургийн уралдаан зарлаж байна.

<p>Зорилго:</p> <p>Оролцогчид:</p> <p>Бүтээлд тавигдах шаардлага:</p> <p>Шагналын сан:</p> <p>Шалгаруулалт:</p> <p>Бүртгүүлэх хугацаа:</p> <p>Нэмэлт мэдээллийг:</p>	<p>Монгол орны байгалийн үзэсгэлэн, өвөрмөц онцлогийн талаар хуралд оролцогчид, оюутан суралцагчдад сурталчлах</p> <p>Гэрэл зураг сонирхогчид өөрсдийн авсан зургаар оролцоно. Нэг оролцогчийн ирүүлэх зургийн тоонд хязгаар тавихгүй.</p> <p>-Сэдвийн дагуу байх -Гэрэл зураг нь тухайн оролцогчийн өөрийн авсан зураг байх -Зураг бүр оноосон нэртэй байх -Зургийг 20x30 хэмжээтэй угаалгасан байх</p> <p>1-р байр: 1 хүн- Өргөмжлөл, үнэ бүхий зүйл 2-р байр: 1 хүн- Өргөмжлөл, үнэ бүхий зүйл 3-р байр: 2 хүн- Үнэ бүхий зүйл</p> <p>Уралдааныг комисс 2017 оны 01-р сарын 11-нд дүгнэнэ. Уралдаанд ирсэн шилдэг зургуудаар үзэсгэлэн гаргана.</p> <p>Гэрэл зургийг 2017 оны 01-р сарын 09 хүртэл БОАЖЯ-ны 313 тоотод хүлээн авна. Иргэний үнэмлэхтэйгээ хүрэлцэн ирж, уралдаанд оролцох зурагаа комисст өгнө.</p> <p>Майл хаяг: mne.mongolia2016@gmail.com Утас: 260718, 99989545</p>
---	--

ХААН банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2484.00	2494.00	ФУНТ	3015.00
ЕВРО	2545.00	2615.00	РУБЛЬ	38.80
ИЕН	20.90	21.22	ЮАНЬ	356.90

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2480.00	2494.00	ФУНТ	3035.00
ЕВРО	2551.00	2633.00	РУБЛЬ	39.49
ИЕН	20.82	21.47	ЮАНЬ	356.50

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

“ХИЛИЙН БҮСЭЭС 100 КМ ХАСАХГҮЙ ГЭЖ ОРУУЛЖ ИРСЭН Ц.НЯМДОРЖ ГИШҮҮНД ТАЛАРХАЖ БАЙНА”



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

Хууль зүйн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Монгол Улсын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцлээ. Хуралдааны эхэнд УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой асуудал хэзээ орж ирэх вэ? хэмээн асуусан. Түүний асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд “Эрдэнэт үйлдвэрийн 49 хувьтай холбоотой асуудлыг шалгах ажил явж байгаа. Ажлын хэсэг долоохонгогт хоёр удаа хуралдаж байна. Шалгах асуудал багагүй байна. “Эрдэнэт” үйлдвэрийн асуудал оноос өмнө нэг талдаа гарна” гэв. Ингээд байнгын хорооны хурлыг эхлүүлэв. Хэлэлцүүлгийн эхэнд УИХ-ын гишүүн Л.Болд “Хуулийн төсөл

хилийн цэрэг хилийн цагдаа болно гэх мэтээр улстөржөөд ойлгомжгүй болоод байна. Шалганы асуудлыг яагаад хилийн цэрэг рүү шилжүүлж байгаа юм. Ардчилсан нам цөөнх болсон байж болно. Яагаад энэ ажлын хэсэгт манай намын төлөөлөл орж болдоггүй юм. Та нар Үндсэн хуулийг дангаараа өөрчлөх гээд байгаа юм шиг байна билээ. Үл ойшоох байдал чинь газар авч байна. Энэ зөрчлөө арилгахгүй бол Монгол Улс ямар дэглэм, ямар нийгэм рүү шилжих вэ гэдэг асуудал гарч ирнэ” хэмээн бухимдав. Үүний хариуд УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “Болд оо, ярьж байгаа зүйлдээ хяналттай байх нь чамд элзийтэй байх. Хил хамгаалах байгууллага 90 жилийн түүхтэй. 20 гаруй байнгын ажиллагаатай боомттой. Шинэ байгуулсан Гадаадын иргэн, харьяатын газар ажлаа хүчрэхгүй байгаа учраас шалгалтын асуудлыг буцаад хилийн цэрэг рүү шилжүүлэхээр болж байгаа юм. Та нар ялагдсан гомдлоо энд ярихаа боль. Зүгээр л Хилийн тухай хуулиа яриач дээ” гэлээ.

юм бэ. Мөн хилийн маргааныг энхийн журмаар шийднэ гэж байна. Хилийн аюулгүй байдал дээр харамсалтай жишээнүүд байдаг. Хилийн зөрчлийг яаж энхийн журмаар шийдэх вэ.



УИХ-ын гишүүн Ц.Нямдорж:

“Ажлын хэсгийн хүрээнд гарсан саналын тухайд тайлбарлах үүрэгтэй. Н.Учрал гишүүн өөрийн саналаа бичгээр өгч хураалгаж болно. Хил хамгаалах байгууллага хил дээр үйл ажиллагаа явуулбал тусгай хэрэгсэл хэрэглэдэг. Зөвхөн хилийн боомт дээр шаардлагатай тохиолдолд тусгай хэрэгсэл хэрэглэдэг. Хилийн боомтууд дээр хил хамгаалахын ангид гаргаж байгаа. Тэнд олон хүнийг хамарсан үймээн болбол цагдаа оролцуулах заалттай байдаг. Хил хамгаалах байгууллага тэргүүн дарга, дэд даргатай байна. Тэр албан тушаалд нь генерал цол олгож байхаар заалт орж ирсэн.



УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ:

“Улс орны агаарын хилийн орон зай хаана харьяалагдаж байна. Агаарын хилийн асуудалд УИХ онцгой анхаарал хандуулаасай гэж хүсч байна. Агаарын хилийн асуудал маш хүнд байдалд орсон байгаа юм байна билээ.



УИХ-ын гишүүн Ц.Нямдорж:

“Засгийн газраас орж ирсэн төсөлд агаарын хилийг агаарын цэрэг хамгаална гэж орж ирсэн. Тиймээс ажлын хэсэг хуралдаад агаарын хил хамгаалах асуудлыг зөвсөгт хүчний агаарын цэрэгт

хариуцуулахаар оруулж өгсөн.



УИХ-ын гишүүн Ж.Ганбаатар:

“Гадаадад явж байхад өөрийн иргэдээ тусдаа байгууллагаар хянуулаад гадны иргэдийг бас нэг байгууллага хянадаг юм уу гэж хараад байдаг. Тэгэхээр гадаадын иргэний асуудлыг яаж вэ?”



УИХ-ын гишүүн Ц.Нямдорж:

“Гадаадын иргэн харьяатын алба чинь өөрийнхөө хуулиар гадаадын иргэнийг оруулдаг, гаргадаг ажлаа л гүйцэтгэнэ. Тиймээс гол боомтууд дээр тэр хуулиараа л явна. Тиймээс энэ асуудалд хилийн газар оролцохгүй.



УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан:

“Энэ хуулийн төслийг дэмжиж байна. Цаг үеийн шаардлагаар гаргасан төсөл гэж ойлгож байна. Хуулийн төсөл дээр ажилласан хүмүүсийн хөдөлмөрийг үнэлэх ёстой. Өмнө нь хилийн бүсийн 100 орчим км-ийг хасах гэсэн оролдлого явсан. Харин хилийн бүсээс 100 км хасахгүй гэж оруулж ирсэн Ц.Нямдорж гишүүнд талархаж байна. Сүүлийн үед захиалгын юм явдаг болсон байна. Ямар учраас хилийн бүсээс 100 орчим км хассан байв.

Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн:

“Хил орчмын нутаг дэвсгэр, хилийн зурвас, хилийн бүс гэсэн гурван ухагдахуун байдаг. Хил орчмын нутаг дэвсгэр гэдэг ухагдахуун бол өөрөө хилийн бүстэй давхцаад байсан

...Энэ статус 1993 оны хуулиас болоод одоо болтол мөрдөгдөөд явж байсан. Тэр үед хилийн бүсэд нэвтрэхдээ иргэний паспорт дээрээ байнгын оршин суугч гэсэн тамга тэмдэгтэй байна гэх мэт олон зүйл заалттай байсан учраас хил орчмын нутаг дэвсгэр гэдгээр оруулсан юм...

юм. Хоёрдугаарт, хилийн бүсэд ямар нэг хориглосон хязгаарласан зүйл байхгүй агаар зөвхөн тийшээ нэвтрэхийн тулд Хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авдаг байсан. Тиймээс нэгэнт хориглосон хязгаарласан зүйл байхгүй тохиолдолд Хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авдаг хүнд суртлыг арилгах гэсэн юм. Иймд бүс, зурвас гээд хүмүүс төөрөгдүүлж байхаар Хил орчмын нутаг дэвсгэр

гэдэг агуулгаар явах нь зөв гэж шийдээд оруулаж ирсэн юм. 100 км гэж хатуу тогтоосон зүйл байхгүй. 100 км гэдгийг баримжаагаар тогтоохоос өөр арга байхгүй. Хилийн бүсийг тогтоохдоо хөрш оронтой зах нийлэн хиллэж байгаа сумдын нутаг дэвсгэрийг хэлнэ гэж олон улсын гэрээнд заасан байдаг. Тиймээс Хил орчмын нутаг дэвсгэр гэдэг нь тодорхой байх юм болов уу гэж ажлын хэсэг ярилцаад оруулж ирсэн. Бүс гэдэг 100 км гэдэг ойлголт бол анх сайд нарын зөвлөлийн 321-р тогтоолоор бий болсон статус. Энэ статус 1993 оны хуулиас болоод одоо болтол мөрдөгдөөд явж байсан. Тэр үед хилийн бүсэд нэвтрэхдээ иргэний паспорт дээрээ байнгын оршин суугч гэсэн тамга тэмдэгтэй байна гэх мэт олон зүйл заалттай байсан учраас хил орчмын нутаг дэвсгэр гэдгээр оруулсан юм. Гэвч хэлэлцүүлгийн шатанд гишүүд бүс байх нь зүйтэй гэдэг санал гаргасан тул буцаагаад бүс гэдгээр оруулахаар шийдсэн. Гэхдээ бүсэд нэвтрэх журмыг ард иргэддээ хөнгөн, шуурхай, хүнд суртлыг арилгах тал дээр анхаарч ажиллах болно.

Ийнхүү гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа зарчмын зөвлөлийн 360 орчим саналаар санал хураалт явуулахаар болов. Дугаар шилжих мөчид зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явагдсаар байлаа.

MINFO

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТӨГТӨХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТӨГТӨХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**
Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

Хэлэлцүүлгийн шатанд гишүүд асуулт асууж, үг хэллээ.



УИХ-ын гишүүн Н.Учрал:

“Шалганыг Хил хамгаалах байгууллага руу шилжүүлж байгааг дэмжиж байгаа. Гэхдээ энэ хуулийн төсөл дээр Улсын хил хамгаалах байгууллагын дарга, тэргүүн дэд дарга, орлогч дарга нь цэргийн дээд цолтой байна гээд заачихсан байна. Энэ нь даргын орон тоог хуулиар тогтоож байгаа буруу жишиг тогтоож байна. Түүнчлэн энэ хуульд тусгай хэрэгсэлийн асуудлыг гайхаад байна. Яагаад тусгай хэрэгсэлийг нь нэг бүрчлэн зааж өгөөд байгаа

АЙЛЧЛАЛ

М.Энхболд Кувейт улсад айлчилж байна

УИХ-ын дарга М.Энхболд энэ сарын 20-ны өдрөөс Кувейт Улсад албан ёсны айлчлал хийж байна. Түүнийг Эль-Кувейт хотын нисэх буудалд Кувейтийн Үндэсний Ассамблейн (парламент) дарга, Эрхэмсэг ноён Марзук Али Аль-Ганим угтан авч хүндэтгэл илэрхийллээ. Айлчлалын эхний өдөр УИХ-ын дарга М.Энхболдод Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн Ерөнхий захирал Абдулвахаб Ахмед Аль-Бадер бараалхжээ. Эрхэмсэг ноён Абдулвахаб Ахмед Аль-Бадер УИХ-ын дарга М.Энхболдод Кувейт Улсад тавтай морилон саатахыг хүсээд “Кувейтийн сан”-гийнхаа талаар танилцуулав. Тус сан өнөөгийн байдлаар дэлхийн 160 улстай хамтран ажиллаж, энэ санхүүгийн жилд 1.9 тэрбум ам долларын хөнгөлөлттэй зээл олгоод байгаа аж. Тэрбээр “Манай улс Монгол Улстай 20 орчим жилийн харилцааны түүхтэй. Сүүлийн жилүүдэд

харилцаа удааширч, зарим асуудал шийдлээ хүлээж байна” гэж тэмдэглээд Монголын парламентын ордны барилгын санхүүжилтэд бид 12 сая ам доллар олгосон боловч газрын асуудал шийдэгдэхгүй удааширсаар, Хүүхдийн эмнэлэг барихад зориулахаар боллоо гэсэн. Хамгийн сүүлд уг хөрөнгийг Түлэнхийн төвийн барилгад шилжүүлэх санал тавиад байна. Мөн Шүрэнгийн УЦС-ын төслийн хөрөнгө оруулагчийн асуудал байгаа. Бид холбогдох судалгааг хийгээд танай талын техник эдийн засгийн үндэслэлийг хүлээж байна. Цаашид зам тээвэр, эрчим хүчний чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх бодолтой байна” гэлээ. Харин УИХ-ын дарга М.Энхболд “Монгол-Кувейтийн хамтын ажиллагаа харьцангуй богинохон түүхтэй боловч авто зам, эрчим хүч, хүмүүнлэгийн салбарт та бүхний хийж хэрэгжүүлсэн төсөл, тусламж

дэмжлэгт манай ард түмэн ямагт талархалтай ханддаг. Парламентын ордон барихад зориулан олгосон санхүүжилтийг ард түмний эрүүл мэндийг хамгаалах байгууллагад шилжүүлэхийг дэмжиж байна. Шүрэнгийн УЦС-ын асуудлаар тодорхой шийдвэрийг Засгийн газраас гаргах байх. Манай эдийн засаг хүндрэл бэрхшээлтэй тулгараад байгаа учраас Засгийн газар энэ байдлыг гэтлэн давах тусгай хөтөлбөр гаргаад ажиллаж байгаа. Олон улсын банк, санхүүгийн байгууллага, сайн харилцаатай улс орнуудын дэмжлэг бидэнд нэн чухал байна. Түүнчлэн танай улс, “Кувейтийн сан”-тай уул уурхай, хөдөө аж ахуй, барилга, аялал жуулчлалын зэрэг салбарт хамтран ажиллах боломжтой гэж үзэж байна. Та бүхнийг, Сангийн удирдлагыг Монголд айлчилж, хамтран ажиллах асуудлаар газар дээр нь үзэж танилцахыг урьж байна” гэлээ.

Төрийн далбааг гутаагч Ц.Мөнх-Оргилд хариуцлага тооцооч

Ж.ӨӨДЛӨН

Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсын Гадаад хэргийн сайд Пракаш Шаран Махатын урилгаар Балба улсад энэ сарын 19-20-ны өдрүүдэд албан ёсны найрсаг айлчлал хийсэн. Гэтэл тэрбээр Балба Улсын Ерөнхийлөгч Бидья Деви Бхандаритай уулзах үеэрээ хэмжээний хувьд алдаатай, эвийн загасгүй, хаанаас хэн олж ирсэн нь тодорхойгүй далбааны өмнө зогссон зураг сошиалаар шуугиулаад авлаа. Гэтэл түүний айлчлалын албан ёсны мэдээллийг Гадаад харилцааны яам өөрийн цахим хуудсанд оруулахдаа буруу далбааныхаа зургийг фотошоп программаар янзлаад оруулчихсан байх жишээтэй. Харин тус яамныхны “нүглийн нүдийг гурилаар хуурсан” энэ үйлдэл тав алхалгүй баригдав. Өөрөөр хэлбэл, ГХЯ-ныхан зөвхөн Монголдоо сэтгэж “тэнэгтсэн” хэрэг. Интернет харилцаа холбоо эрчимтэй хөгжиж байгаа энэ зуунд Балба Улсын мэдээллийн сайт дээр өнөөх зураг нь дурайж байлгүй яах вэ дээ. Гадаад харилцааны сайд буруу харуулчихсан төрийн далбааны өмнө мишээгээд, зогсож байхдаа төрийн далбаагаа нэг харчих ухаан байхгүй байсан нь харамсалтай. Уг нь Монгол Улсын далбааг Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулиар хамгаалж өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл, санаатай ч бай, санамсаргүй ч бай Монгол Улсын төрийн далбаа ашиглахдаа хариуцлага хүлээх учиртай гэсэн үг. Тэгвэл энэ хууль Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилд үйлчилдэггүй бололтой. Эсвэл өнөөх МАН-ын 60 тэрбумын асуудал шиг мөн л эвлүүлэг болгоод өнгөрөх үү.

Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

УЛС ТӨР

САЙД ЯРЬЖ БАЙНА



бууруулах БОАЖЯ-ны чиглэлээр цаашдын бодлого, чиглэл юу вэ?

-Агаарын бохирдолттой өнөө маргаашаа бодож, амна аргаасаан байдлаар тэмцээд үр дүнд хүрэхгүй. Тиймээс бид Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөртэй болох шаардлагатай. Хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж байна. Цаашид түүхий нүүрсний хэрэглээг нийслэлд хязгаарлах ёстой гэсэн бодлогыг БОАЖЯ-наас барьж байна. Мэдээж түүхий нүүрсний хэрэглээг өнөөдөр шууд зогсоох боломжгүй. Нүүрсний орлох сайжруулсан түлшний үйлдвэрийг дэмжих бодлого барьж ажиллана. 1950-иад оны эхээр Лондон

байгаа төлбөрийг нүүрс угаахад зарцуулах шаардлагатай гэж үзэжбайгаа. Нүүрсшингэрүүлэн хий гаргах үйлдвэрийг дэмжих, нийслэлийн зарим гэр хорооллын айл өрхийн халаалтыг хийн халаалтаар шийдэх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих, үнэ тарифыг бууруулах, айл өрх цахилгаанаархалаалтаашидэж байгаа тохиолдолд шөнийн цахилгааны урамшуулал олгох ажлуудыг үргэлжлүүлэн шат дараатай хийнэ. Агаарын бохирдлыг бууруулах стратеги, төлөвлөлтөө боловсронгуй болгох, насжилт ихтэй автомашины татварыг нэмэгдүүлэх замаар хэрэглээнээсхасах, нийслэлийн эрчим хүчний эх үүсвэрийг

Д.ОЮУНХОРОЛ:

ТҮҮХИЙ НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭГ НИЙСЛЭЛД ХЯЗГААРЛАХ ЁСТОЙ

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Цочмог болон архаг гуурсан хоолойн үрэвсэл, уушгины үрэвсэл, багтраа, харшил, ларингитийн өвчлөл эрс ихэсч түүнд хүүхэд, өндөр настан, архаг хууч өвчтэй хүмүүс илүү ихээр өртөж байна. Түүхий нүүрсний хэрэглээ, автомашины түлшний дутуу шаталт, үйлдвэрийн болон барилгын тоосжилт зэргээс үүсдэг PM2.5, PM10 гэдэг үл үзэгдэгч тоосонцорууд хүний эрүүл мэндэд хохирол учруулдаг. Хавдар үүсгэх хорт нэгдлүүдийг агуулдаг эдгээр тоосонцорууд уушгины гүнд шигдэж, зүрч судас, амьсгалын замыг өвчлүүлж, хүний дархлааны системийг устгадаг аюултай. Агаарын бохирдлын асуудал үнэхээр сэтгэл түгшээх хэмжээнд хүрсэн учраас ард иргэд багагүй шүүмжилж, эрүүл мэндээ хамгаалах талаар санал санаачилгууд гаргаж байна. Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг үл үзэгдэх тоосонцруудыг багасгаж, бохирдлыг багасгахын төлөө бид тууштай ажиллах шаардлагатай. Агаарын бохирдлын гол эх үүсвэр болсон түүхий нүүрсний жилд Улаанбаатар хотын хэмжээнд жилд 5.9 сая тонныг хэрэглэдэг. Үүнээс гэр хороололд 10 хувийг нь хэрэглэж байгаа боловч агаарт ялгаруулж байгаа бохирдлын 80 хувийг эзэлж байна. Цахилгаан станцууд түүхий нүүрсний 85 хувийг нь хэрэглэж байгаа боловч агаарт ялгаруулж байгаа бохирдлын хувь хэмжээний зургаан хувийг эзэлж байна. Мөн Улаанбаатар хотод явж байгаа тээврийн хэрэгсэл агаарт ялгаруулж байгаа бохирдлын хувь хэмжээний 10 хувийг ялгаруулдаг. Энэ нь нийт тээврийн хэрэгслийн 60 хувь нь 10-аас дээш жилийн насжилттай байгаагаар холбоотой.

Дээрх арга хэмжээний үр дүнд Улаанбаатар хотын агаарын чанар тэр дундаа PM2.5 тоосонцорын хэмжээ бага хэмжээгээр буурсан үзүүлэлт гарсан байдаг.

НҮБ-аас хүүхдийнхээ дөргэд тамхи татахгүй байх, нөгөөтэйгүүр иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх хэрэгтэйг зөвлөсөн байсан. Өөрөөр хэлбэл, агаарын бохирдлыг бууруулахад их мөнгө зарахгүй ажлуудыг энэ мэтчилэнгээр төлөвлөсөн зүйл бий юу?

-Агаарын бохирдлыг бууруулахад хүн бүрийн хүчин зүтгэл хэрэгтэй. Урт хугацааны тууштай, зөв бодлого, төр, хувийн хэвшил, ард иргэдийн хамтын уйгагүй хүчин чармайлтын үр дүнд бид агаарын бохирдлоос салж чадна. Өнөөдөр утаатай тэмцэх чиглэлээр ард иргэд маш их шүүмжилж байгаа боловч бодитой оролцоо хангалтгүй байна. Агаарын бохирдлоос салсан улс орнуудын туршлагыг харахад орон нутгийн засаг захиргааны байгууллага нь илүү идэвх санаачилгатай манлайлан ажиллаж, хяналтыг шат дараатай тавьж, ардиргэдтэйгээ хамтран ажилласнаар үр дүнд хүрсэн байдаг. Тухайлбал, Япон улсад 1960-аад онд химийн багш агаарын бохирдлыг бууруулах хөдөлгөөнийг эхлүүлж, орон нутгийн байгууллагдаа бодитой санал дэвшүүлж, хамтран ажилласан жишээ байдаг юм билээ. Энэ мэтээр дээрээсээ биш, доороосоо эхэлсэн бодитой санаачилга, хөдөлгөөн үр дүнд илүү хүрнэ. Утааг багасгахад иргэн бүрийн бодитой үүрэг, оролцоо чухал гэдгийг бүгдээрээ ухамсарлаасай. Наад зах нь түүхий нүүрсээ хашаандаа нл задгай буулгахгүй байх, үнсээ битүүмжилсэн саванд хийж сурах хэрэгтэй байна. Агаарын бохирдлыг бууруулах ард иргэдийн оролцоог сайжруулахын тулд утааны хор уршигийн талаар болон урьдчилан сэргийлэх, тэмцэх арга, хүн бүрийн оролцоог бодитой болгох чиглэлд хандсан сурталчилгаа, мэдээллийг хийх шаардлагатай. Энэ чиглэлээр бид зарим ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Энэ сарын эхээр хуралдсан Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос Улаанбаатар хотын ногоон хөгжлийн стратегийг хэрэгжүүлж, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн нийгмийн аяныг өрнүүлэх ажлыг хийхүүргийг Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газарт өгсөн. Жишээ нь, Японд жолооч нарын хариуцлага өндөр байдаг. Жолооч нарын 70 хувь нь эко жолоодлого хийх дадалтай болсноор шатахуун зарцуулалтыг багасгаж, агаар бохирдуулах бодисын ялгарлыг 45 хувиар бууруулж чадсан

байна. **-Эрчим хүчний сайд орон сууцны дулааныг хийн эх үүсвэрээр шийдвэрлэх ажил хийхээр төлөвлөсөн гэж мэдэгдсэн. Энэ мэтчилэн яам агентлагууд агаарын бохирдлыг бууруулахад ямар үүрэг оролцоотой ажиллаж байна вэ. Агаарын бохирдолттой ганц хоёрхон газар тэмцээд нэмэргүйг өнгөрсөн хугацаанд харсан шүү дээ?**

-Агаарын тухай хуулиар бүх салбар, яамдагаарын бохирдлыг бууруулах үүрэг хүлээдэг. Энэ дагуу Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны хуралдаанаас бүх яамдад албан үүрэг өгсөн. Тухайлбал, хог хаягдал сэргээн ашиглах, эрчим хүч үйлдвэрлэх төслийг дэмжих ажиллахыг Үндэсний хорооны бүх гишүүдэд өгсөн. Байгалийн хийгээр халаалт шийдэх асуудал нь урт хугацааны бодлогодоо бол зөв алхам. Ойрын хугацаанд эдийн засгийн хувьд боломжгүй. Хийн түлш үйлдвэрлэх төсөл хэрэгжих боломжтой хэдий ч дэд бүтцийн зардал маш өндөр өртөгтэй гардаг тооцоо судалгаа бий.

“Цэвэр агаар сан”-г сэргээх, гэр хорооллын өрхийн дулааныг цахилгаан хангамжаар шийдэх, уурын болон усны халаагуурын зуух ашиглах, агаарын бохирдлыг бууруулах сангай болох зэргээр олон ажлыг хэлэлцүүлэг дээр ярьж байсан. Эдгээр ажлуудыг хэрхэн төлөвлөж хэзээнээс эхлүүлэх вэ?

-Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны анхны хуралдаанаар өнөөдөр, цаашид, дунд хугацаандаа бид агаарын бохирдлыг бууруулах талаар юу хийх, ямар зорилт тавьж ажиллахаа хэлэлцэж, шийдвэрлэсэн. Улс орны эдийн засаг хүндрэлтэй нөхцөлд өмнөх жилүүд шиг их мөнгө зарцуулах боломжгүй байна. Гэхдээ бүх нөөц боломжоо шавхан ажиллах шаардлагатай. Эхний ээлжинд бид “Цэвэр агаар сан”-г эргэж байгуулахаар ажиллаж байна. Уг санд Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиар дөрвөн төрлийн татвар төвлөрдөг. Санг сэргээн байгуулснаар уг татварын мөнгийг агаарын бохирдолттой тэмцэх зориулалтын дагуу ашиглах боломж бүрдэнэ. 2017 онд агаарын бохирдлыг бууруулахад таван тэрбум тогрөг төсөвлөсөн. Үүнээс 3.5 тэрбум тогрөгийг шөнийн цахилгааныг төглэхэд зарцуулна. Сайжруулсан зууханд 450 сая, сайжруулсан түлшинд 400 сая зарцуулахаар төлөвлөсөн. **-Өмнөх жилүүдийг бодоход энэ жил нэлээд бага мөнгө төсөвлөсөн байна. Сайжруулсан зуух, утаагүй түлшинд 900 саяг**

зарцуулаа гээд хэр үр дүнд гарах бол?

-Энэ удаа сайжруулсан зуух, түлшийг зорилтот бүлэгт нийлүүлэх бодлого барьж байна. Нийслэлийн 198 мянган айл өрхийн 30 хувь нь агаарыг ихээр бохирдуулагч, хүний эрүүл мэндэд онц хортой зүйл түлдэг гэсэн судалгаа бий. Эдгээр иргэддээ сайжруулсан түлш, зуух тараана. Ингэснээр агаарын бохирдолт хамгийн багадаа 10 хувиар буурна гэж үзэж байгаа. Сайжруулсан зуух, түлшний хөнгөлөлт зорилтот бүлэгт чиглэснээр тухайн иргэддээ, нийтийн эрх ашигт ч хэрэгтэй гэж үзэж байгаа.

-Агаарын бохирдлыг

хот агаарын бохирдлын гамшгаас салж чадсан түүх нь түүхий нүүрсний хэрэглээг хориглосонд байсан. Түүхий нүүрсийг хориглоод цахилгаан болон хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлж, Агаарын чанарын бүсүүддээ онцгой хяналт тогтоож утаанаас салсан түүх байдаг. Гадны энэ мэт сайн жишээ, туршлагыг бид хэрэгжүүлэх хэрэгтэй. Цаашдаа агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, хамрагдах дүүрэг хороодын тоог нэмж, сайжруулсан зуух, боловсруулсан түлшээр хангах ажлыг ойрын таван жилд зохион байгуулахаар төлөвлөж байна. Нүүрс олборлогчоос авч

балтгаатай болгох, нийтийн тээврийг хийн түлшний хэрэглээнд шилжүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Өнөөдөр Монголын нийт хүн амын тал хувь нь нийслэл хотдоо амьдарч байгаа учраас төвлөлийн сааруулах, нийслэл хотоо талэх бодлогыг явуулах ёстой. Гэр хорооллыг орон суужуулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай ч өнөөдөр ашиглалтад орсон 130 мянган орон сууц худалдан авагчаа хүлээж байна. Ард иргэдийн маань худалдан авах чадвар сайнгүй байгаа учраас энэ бол аажмаар үр дүнгээ өгөх бодлого юм.

БАЙНГЫН ХОРОО

Д.Даваасамба: Бичил уурхай нэрийн дор байгаль сүйтгэж байгаа нь үнэн

Ж.ӨӨДЛӨН

УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар уул уурхайн улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг хэлэлцлээ. Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхэд хөндөгдсөн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах асуудлыг судалж, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал, дүгнэлтийг боловсруулсан тухай танилцуулгыг УИХ-ын гишүүн Ё.Баатарбилэг хийв. Тэрбээр, Өргөдлийн байнгын хороонд иргэдээс уул уурхайн үйл ажиллагааны

...Орон нутгийн ИТХ-аас тогтоол гардаг, энэ нь холбогдох хууль тогтоомжид нийцдэггүй. Бичил уурхайн нэрийн дор байгаль сүйтгэж байгаа нь үнэн. Энэ ажлыг таслана зогсоох ажил явагдаж буй хэдий ч бодит үр дүнд хүрэхгүй байна. Иймд хууль эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлага тулгараад байна гэв...

их хэмжээний тэслэгэний дуу чимээ, тоос шороо, газрын эвдрэл, гэмтэл хүн, малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа гомдол ирдэг. Түүнчлэн ундны усны хомсдол үүсгэж эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг алдагдуулж байгаа тул хяналт шалгалт хийлгэх, буруутай этгээдэд хариуцлага тооцон, учирсан гэм хорыг арилгуулах, Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, уул уурхайн тусгай зөвшөөрлийг цөөрүүлэх зэрэг асуудлаар өргөдлүүд тогтмол ирүүлж байна. Иргэдийн өргөдлийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Уулсын мөрдөн байцаах газар, 17 аймаг, нийслэлийн Засаг даргын мэдээлэлд үндэслэн гаргав гээд Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй танилцуулга хийсэн юм. Үүнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54.11 дэх хэсэгт Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлнэ гэж заасныг хэрэгжүүлэх журам гаргах шаардлагатай байна. Иймд Байнгын хорооноос

Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх саналтай байна гэлээ. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн сүүлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэлээс нөхөн сэргээлтийн асуудал орхигдсон байдаг. Үүнтэй холбогдуулан бичил уурхайг цаашид хэрхэхийг тодруулсан юм. Харин Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Д.Даваасамба “Орон нутгийн ИТХ-аас тогтоол гардаг, энэ нь холбогдох хууль тогтоомжид нийцдэггүй. Бичил уурхайн нэрийн дор байгаль сүйтгэж байгаа нь үнэн. Энэ ажлыг таслана зогсоох ажил явагдаж буй хэдий ч бодит үр дүнд хүрэхгүй байна. Иймд хууль эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлага тулгараад байна гэв. Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Д.Очгэрэл бичил уурхайтай холбоотой гэмт хэрэг өссөн үзүүлэлт гарсан. Нөхөн сэргээлт хийх нэрийдлээр хууль бус үйл ажиллагаа хийгдсэн байсныг тогтоосон. Сүүлийн дөрвөн жилийн байдлаар 210 хэрэг бүртгэгдсэнээс 11 орчим хувь нь шүүхээр шийдвэрлэгдсэн” гэлээ.

ОНЦЛОХ ХУУДАС

Өүг үү өүг аү?

ТӨРД АЖИЛЛАСАН ТУРШЛАГАТАЙ САЙД

Н.ПУНЦАГБОЛД

“Монголын мэдээ” сонин “Хэн нь хэн бэ” булангаараа Засгийн газрын сайдуудыг онцолж байгаа билээ. Энэ удаад БСШУС-ын сайд Ж.Батсуурийг онцолж байна.



Гэрэл зургийг Г.АРУУЖИН

Засаг даргаас гишүүн, сайд болсон эрхэм

МАН 2016 оны сонгуулиар үнэмлэхүй ялалт байгуулсны дараа “Мэргэжлийн” Засгийн газрыг байгуулсан. Тэгвэл энэ Засгийн газарт орж ажилласан тулхтай, туршлагатай, олон жил төрд ажилласан нэг сайд багтсан нь Ж.Батсуурь. БСШУС-ын сайдаар томилогдож ажиллаж байгаа юм. Мөн цөөнгүй хэдэн дан дээлтэй сайд байгаагийн нэг нь тэр. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар мэргэжлийн хүн томилно гэж ярихад бас өрөөсгөл. Олон жил багш хийсэн, шинжлэх ухааны доктор цолтой, соёл, спортод нэвтэрхий хүн ч юу байх билээ. Тийм болохоор төрд ажилласан туршлагатай, тэр дундаа удирдах албан тушаал хашиж байсан, сайн баг бүрдүүлж чадах хүнийг л томилох хэрэгтэй байх. Магадгүй тэр шалгуурт нийцэх хүмүүсийн нэг нь Ж.Батсуурь сайд. Тэрбээр 1983 оноос эхлээд багш мэргэжлээр ажиллаж байсан нэгэн. 1994-1998 онд Чех улсын Прага хотын Техникийн их сургуулийн докторант багшаар ажиллаж байсан. Улмаар 1998 оноос эхлээд төрийн албанд зүтгэж, Дорноговь аймгийн Засаг даргаар 2000-2008 он хүртэл суусан. Түүний дараа УИХ-ын гишүүнээр 2008, 2012 онд сонгогдон, найман жил суусан. Ийм л төрийн албаны туршлагатай хүн. Тэр дундаа олон жил багшаар ажиллаж байсан болохоор Монгол Улсын боловсролын салбарын асуудлыг яс махаараа мэдрэх нь ойлгомжтой. Дээрээс нь өмнөх бодлогуудаа тас үгүйсгэж, өөрийнхөө өнцгийг чихэх гэж дайрахгүй болов уу

гэж санагдаад байгаа. Тэрбээр боловсролын салбарт туршлагатай хүн гэдгээ баталж, энэ чиглэлээр цөөнгүй ажил хийж, хэрэгжүүлж эхлээд байгаа. Ялангуяа Орост айлчлах үедээ зарим нэг ажлыг шийдсэн. Хөгжим бүжгийн дунд сургуулийг Хөгжмийн их сургууль болгохоор ажиллаж байгаа. Оросууд энэ тал дээр дэмжлэг үзүүлнэ гэж мэдэгдсэн. Мөн тэрбээр ажлаа авснаас хойш оюутнууд сургалтын төлбөрөө зээлээр авах боломжийг бүрдүүлж, шийдэж өгсөн. Бүр банкуудын төлөөлөлтэй уулзаж, хамтран ажиллахаар болчихоод байгаа. Хэдийгээр энэ асуудлыг өмнөх Засгийн газрын үед ярьж, шийдэх эхлэлийг тавьсан. Харин яг гардаж шийдсэн нь Ж.Батсуурь сайд. Байшингийн суурийг хэн тавих нь хамаагүй. Барьж, босгож, ашиглалтад хэн оруулсан бэ гэдэг нь л чухал шүү дээ. Тийм болохоор Боловсролын сайдын боловсролын салбарт оруулж байгаа энэ том хувь нэмрийг дурьдахгүй өнгөрч болохгүй. Ингэснээр өнөөдөр олон оюутан сургалтын төлбөрөө зээлээр авах боломж бүрдэж байгаа юм. Цаашлаад зээл авахын тулд сурлагадаа анхаарна, онц сурахын төлөө зүтгэнэ. Намрын намарт эцэг, эхчүүд цалингийн зээлээс авахуулаад бөөн асуудал болдог байдал ч нааштайгаар шийдэгдэж байгаа юм. Мөн тэрбээр тушаал гаргаж, багш, сурагчдын гарутасны хэрэглээг хязгаарлахаар болсон. Тэгэхдээ иргэдээс ирсэн хүсэлтийг үндэслэсэн юм билээ. Юуг үндэслэх нь гол биш, хязгаарлаж байгаа нь чухал. Тэр дундаа ухаалаг утасны хэрэглээг ч хязгаарлах нь зөв. Өнөө цагт багш, сурагчгүй ухаалаг утас “маажиж”

суугаад, чанартай боловсрол алдагдах нөхцөл байдалд ч хүрэхдээ тулчихаад байгаа юм. Тийм болохоор энэ мэт хэрэглээг хянаж, хязгаарлах журам гаргах нь зөв. Зарим нэг зүйлийг иргэдийн ухамсрын асуудал гээд хаяж болох ч журам, дүрэмтэй бол бүр сайн биз дээ. Гэх мэтээр Ж.Батсуурь сайд тодорхой хэмжээнд ажлаа сайн хийж л явна. Нөгөө талдаа бусад салбарынхаа ажлыг бага сага орхиж дуулаад байна уу даа гэмээр харагдах юм. Тухайлбал, шинжлэх ухаан гэдэг өөрөө маш том салбар. Дээрээс нь соёлын салбар байна. Мөн спорт. Мэдээж ямар ч лаг сайд байсан энэ бүх салбарт хүрч ажиллахад хэцүү л дээ. Ж.Батсуурь сайдын хувьд шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн сонирхож, эрдэмтдэдээ мэндчилгээ дэвшүүлж, мэдлэгт суурилсан эдийн засаг бий болгох ёстой гэж байр сууриа илэрхийлээд, боломжийнхоо хэрээр энэ салбарт анхаарч байна. Мөн амжилт гаргасан тамирчдаа хүлээж авах, тэдний зовлон, жаргалыг сонсох гээд спортын салбарыг ч огт хаячихаагүй л дээ. Яах вэ, ажлаа дөнгөж аваад гурав, дөрөвхөн л сар болж байна. Цаашид бүтэн гурван жил хагасын хугацаа байгаа. Тийм болохоор спортын, урлагийн, шинжлэх ухааны салбарын асуудалдаа анхаарчих биз ээ.

байсан гэдэг утгаараа маш их туршлагатай. Сайддаа хамгийн их түшиг болж ажиллах нэгэн. Мөн харьяа байгууллага, газрын дарга нараар ч гайгүй хүмүүсийг томилсон. Тухайлбал, Биений тамир спортын газрын даргаар МУТТ Ц.Шаравжамц томилогдсон. Өөрөө сагсан бөмбөгийн спортоор хичээллэж, тамирчдын хөлс хүчийг мэдэрч явсан хүний хувьд энэ салбарыг амжилттай удирдаж, сайддаа хамгийн их түшиг болох ёстой хүн. Ерөөсөө энэ газрын даргаар тамирчин хүнийг л томилох хэрэгтэй байсан. Тэр ч ёсоор багаа бүрдүүлсэн. Ц.Шаравжамц дарга болсноор Спортын төв ордонг шинэчлэх асуудлыг шийдэх гээд, гадаадын хөрөнгө оруулалт татах гээд л явж байна. Бүр цогцолбор бүтээн байгуулалт хийж, өөрийнх нь орлогоор хөрөнгө оруулалтаа нөхөх юм гэсэн. Яадаг юм, нэг ч гэсэн сайхан юм хийж л байвал боллоо шүү дээ. Сайхан санаачилга. Энэ бол багаа зөв бүрдүүлсний л ач. Гэх мэтээр гайгүй томилгоонуудыг хийж, багаа зөв бүрдүүлсэн. Энэ хэрээр зөв шийдвэрүүд гарч, ажил урагшилж буй. Намар гэхэд л Ж.Батсуурь сайд их, дээд сургуулиудын захирлуудтай уулзаад, төлбөр нэмэхгүй байх асуудлыг шийдвэрлэсэн. Ерөөсөө сайн сайн, оновчтой шийвэрүүдийг гаргаад л явж байгаа. Яах вэ, ганц нэг шинэ хөтөлбөр энэ тэрийг хэрэгжүүлэх гээд сургуулиуд мунгинаж байгааг алийг тэр гэх вэ. Өмнө нь гарчихсан л байсан шийдвэр. Хамгийн гол нь энэ хүн цоо шинээр баахан юм туршиж, салбараараа тоглоод байхгүй, өмнөх хүмүүсийн хийж байсан зөвийг нь дэмжээд явахаар харагдаад байгаа юм. Гол нь төр залгамж халаатай байх ёстой. Дээрээс нь зөв сэтгэлтэй,

чадвартай, туршлагатай хүмүүсээр багаа бүрдүүлчихвэл ажил ч урагшилла л даа.

Хамгийн сайн ажилласан сайд

“Мэргэжлийн” Засгийн газар байгуулагдсанаас хойш 100 хоногийн хугацаа өнгөрөхөд яам бүр ажлаа тайлагнасан. Тэгэхэд хоёр, гуравхан яам гайгүй сайн ажиллаж, цөөнгүй асуудлыг шийдсэн байсны нэг нь БСШУС-ын яам. Хийсэн ажлуудыг нь дурьдвал цөөнгүй. Зөвхөн 10 хоногт гэлтгүй сайн ажиллаж байгаа нь Боловсролын сайд гэж хэлж болно. Хамгийн чухал нь гэвэл Ж.Батсуурь сайд Дээд боловсролын хуульд өөрчлөлт оруулж, батлуулсан явдал байсан юм. Энэ бол маш чухал ажил. Хуулийг баталснаар шаардлагатай олон өөрчлөлтийг хийж болохоор болчихоод байна. Мөн энд нэг том ажлыг дахиад, бүр тод томруунаар сануулмаар байгаа юм. Тэр бол их, дээд сургуулийн төлбөр нэмэгдээгүй асуудал. Ганцхан энэ ажлынх нь төлөө Ж.Батсуурь сайдын хэдэн удаа ч хэлтгүүлж болохоор. Өмнөх жилүүдэд их, дээд сургуулийн төлбөр 20-30 хувиар байнга нэмэгддэг байсан. Бүр жил бүр. Шалтгааныг нь асуухар инфляци, үнийн өсөлт энэ тэр гэж ял шалихгүй шалтгаан хэлээд л гүйцээ. Энэ бүхэн ард түмэнд ямар их дарамт үүсгэдэг байсныг хэн ч үгүйсгэж чадахгүй. Гэтэл энэ жил сургуулийн төлбөр бараг нэмэгдээгүй. Анх удаа оюутнууд намар хичээлдээ ирэхдээ төлбөр хэд болсон бол гэж бодохгүй, санаа амар сургуульдаа орсон байх. Ердөө л энэ ажлыг амжуулж, сургуулийн удирдлагуудтай тохиролцоонд хүрч чадсаных төлөө түүнийг хамгийн сайн ажилласан сайд гэж зоригтой хэлж чадахаар байна.

...Мэдээж ямар ч лаг сайд байсан энэ бүх салбарт хүрч ажиллахад хэцүү л дээ. Ж.Батсуурь сайдын хувьд шинжлэх ухаан, технологийн үзэсгэлэн сонирхож, эрдэмтдэдээ мэндчилгээ дэвшүүлж, мэдлэгт суурилсан эдийн засаг бий болгох ёстой гэж байр сууриа илэрхийлээд, боломжийнхоо хэрээр энэ салбарт анхаарч байна...

Сайн баг бүрдүүлсэн

Ж.Батсуурь сайдыг харьцангуй сайн баг бүрдүүлсэн гэж дүгнэж болохоор. БСШУС-ны дэд сайдаар өмнө нь энэ салбарыг удирдаж явсан Ё.Отгонбаяр ажиллаж байгаа. Нэг салбарыг овоо хэдэн жил удирдаж, УИХ-д хүртэл сууж



Тал нутгийн цахим мэдээлэл



ЧУХАЛ ХҮН

П.МӨНХЧУЛУУН:

МОНГОЛ АРД ИРГЭ



Гэртэй зурагтай Т.АПИ УУЖИЛ

Н.БАТЗАЯА

Хэвлэлийн салбартаа анхдагчдын нэг "Сэлэнгэ пресс" компанийн Бизнес хөгжлийн албаны захирал П.Мөнхчулууныг энэ удаагийн "Чухал хүн" буландаа урьж, ярилцлаа.

-Юуны өмнө таны бизнесийн салбарт хөл тавих болсон үүх түүхээс ярилцлагаа эхлэх үү. Ер нь та аль нутгийн хүн бэ. Өөрийнхөө талаар товчхон танилцуулахгүй юу?

-Би хотын унаган хүүхэд. Хотод төрж, өссөн. Харин миний аав Ховд аймаг, ээж маань Архангай аймгийн Өндөр-Улаан сумын хүн байдаг. Би Компьютерийн техник, менежментийн сургуулийг 2005 онд төрийн удирдлагын мэргэжлээр төгсч, БНСУ-д олон улсын худалдаа бизнесийн чиглэлээр хоёр жил суралцсан. Мөн Солонгос улсад сервис консалтингийн мэргэжлээр мастераа хамгаалсан. Өөрийнхөө талаар товчхон танилцуулахад ийм байна. Харин бизнесийн салбарт 2008 оноос эхлэн хөл тавьсан гэж хэлж болно. Ер нь 1990-ээд оны үеэр Ардчилсан хувьсгал гарч, нийгэм солигдохтой зэрэгцээд Монголын нийгэм, эдийн засгийн байдал нэлээд хүнд болж эхэлсэн. Тухайн үед хүмүүс амьдрахын тулд ганзагын наймаанаас эхлээд зах дээр худалдаа, наймаа эрхэлдэг байлаа. Би тэдний л нэгэн адил явсан. Зах дээр ундаа зарахаас эхлээд савхин эдлэл хүртэл зарж явсан. Юм юмыг л хийх гэж их оролддог байсан. Хувиараа лангуу, кафе, цайны газар ажиллуулж, бусдын жишгээр л бизнесийн салбарт хөл тавьсан. Яах вэ, их сургуулиа төгссөнийхөө дараа төрийн албан хаагч болох гэж үзсэн ч болоогүй. Шалтгаан нь гэвэл бизнесийн салбарт илүү шударга, нээлттэй цэвэр өрсөлдөөн байдаг учраас энэ салбарыг сонгосон юм. Үүнээс хойш бизнесийн салбарт эргэлт буцалтгүй орсон. 2014 онд Солонгосоос ирснийхээ дараа компани байгуулж, түүнийхээ хажуугаар намд элсэж, олон нийтийн байгууллагад ажилласан даа. Гэхдээ өнгөрсөн

сонгууль дуусахаас өмнө намаасаа гарсан.
-Яагаад намаас гарсан юм бэ. Сүүлийн үед бизнес-мэнүүд намын харьяалалтай байх болсон шүү дээ?
-Намаас гарах болсон минь учиртай. Нам дагаж гүйсэн улстөрч гэх тодотголтой хүмүүсийн чиг хандлага, үзэл санаа, байгаа байдал надтай огт таараагүй. Бид янз бүрийн л нам дагасан холбоод, залуучуудын байгууллагыг мэднэ. Тэд бидний нүдэн дээр гарч ирээд эх орноо хөгжүүлэх талаар ярьж эхэлдэг. Гэхдээ үнэн хэрэгтэй тэр залуус эх орноо хөгжүүлнэ гэхээс илүү намыг мөнгө олох хэрэгсэл болгоод ойлгогчид байдаг. Тэдний эцсийн зорилго болсон ч юм. Нийтлэг чиг хандлага нь тийм. Аль ч нам ялгаагүй, бүгд ижил. Сүүлийн үед "Цүнх баригч" гэдэг нэршил хүмүүсийн дунд бий болсон. Тэр яриа үнэн. Нам дагаж байгаа залуус дотор "цүнх баригч" маш олон. Нэг намын даргын нүдэнд өртчих юмсан, аль нэг намын хараанд өртөөд төрийн байгууллагад ажилд орчих юмсан гэсэн хүмүүс л байдаг. Уг нь улс төрийн эрхмүүд ард иргэдэд ажлын байрыг бий болгох, түүнийг бүтээлхэд өөрийн оюуны болон биенийн хүч хөдөлмөрөө зориулах ёстой. Гэтэл эсрэгээрээ өөрсдөө ажлын байрыг хайгч, албан тушаал горилогч болоод байгаа юм, тэр залуус. Тэгээд үед хүмүүсийн албан тушаалд очихвол төсвийн мөнгөнөөс яаж хумсалцаах вэ гэдэг талаар бодоод эхэлдэг. Энгийн жишээ хэлье. Энэ бүгдийг би нүдээрээ харсан учраас яриад байгаа юм шүү. Энэ явдал намайг улс төрийн салбараас холдоход томоохон нөлөө үзүүлсэн гэж ойлгож болно. Би гурван жил намын гишүүн байсан хүн. Тэгэхэд яг надтай ижил хугацаанд намд орсон залуу "Эжийн маань лизингийн байрнаас өөр хөрөнгө надад байхгүй" гэж ярьж байсан юм. Гол нь тэр залуу ард түмний өмнө гарсан, шударга ёс, хууль дүрмийн талаар ярьсан, үүний үр дүнд төрийн нэг албан тушаалд томилогдсон. Түүнээс хойш л GClass-500 унаж, хэдэн саяын үнэтэй тансаг зэрэглэлийн хаусанд амьдарч эхэлсэн. Төрийн энгийн нэг албан хаагч яаж тэгж огцом

баяжиж, амьдрал нь дээшилсэн байх вэ. GClass-500 гэдэг машин 200 сая төгрөгийн үнэтэй. Харин тэр хүний авч байгаа цалин тэр машины 10 хувьд ч хүрэхгүй шүү дээ. Тэр залуугийн амьдрал огцом дээшилсэн түүх ойлгомжтой, улсын төсвийн хөрөнгө, төндэрээс мөнгө унагаасан. Үнэхээр тэр хүмүүст хийж бүтээсэн зүйл байхгүй. Зүгээр л нам дагаж, намын даргын цүнх барьж гүйсэн. Ерөөсөө л улс төрийн тогоонд орсон бүх хүмүүс бүлэглэж байгаад эх орныхоо хэдэн нөөц байлгийг хувааж идэх гэсэн сонирхолтой болчихсон байсан. Энэ бүхнийг хараад үнэхээр харамссан, бас их бухимдсан. Уг нь би Солонгос улсаас эх орныхоо төлөө ихийг хийж бүтээж, Монгол Улсаа хөгжүүлнэ гэсэн өөдрөг үзэлтэй ирсэн хүн. Миний үеийн, гадаадад суралцаж байсан залуус бараг бүгд сургуулиа төгсөөд эх орондоо буцаж ирцгээсэн шүү. Тухайн үед Засгийн газраас гадаадад суралцаж буй залуусыг эх орондоо авч ирэх зорилго бүхий "Зөгийн үүр" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт, хөгжмийн зохиолч Н.Жанцанноров гуай Солонгост суралцаж их, дээд сургуулийн оюутнуудад лекц уншиж явсан буй залуусыг эх орондоо авч ирэх зорилго бүхий "Эх орноо хөгжүүлнэ. Монголоо очоод их зүйлийг бүтээнэ" гэсэн нэгэн хүсэл, зорилго тэмүүлэлтэйгээр буцаж ирсэн. Тэдэн дунд Солонгост ажиллах ажлын урилга авсан залуус ч байсан шүү. Миний хувьд гэхэд л гурван газраас ажлын урилга авсан. Тухайлбал, Соёл глобал төв, Цахим их сургуулийн сургалтын албаны менежерээр ажиллах, мөн бизнесийн салбарт хамтарч ажиллах саналууд ирсэн хэдий ч би эх орноо сонгосон. Гэтэл эх орондоо ирээд бизнес эрхлэхийн хажуугаар бүтэсэн, ард иргэдийнхээ амьдралыг доройтуулсан улс төрийн салбарт орж, дотроос нь шинэчлэл хийе гэж бодсон чинь би ганцаараа зүтгээд ч

барахааргүй илжирсэн байсан. Тийм учраас намаас гарсан. Хоёрдугаарч, бизнесийн салбарт цэвэр шударга өрсөлдөөн явагддаг учраас шударга, үнэнч байдлыг эрхэмлэдэг. Тэр зарчимтай минь хүртэл харшилдаж байсан болохоор намаас гарах шийдвэрт хүрсэн юм. Яах вэ, сонирхуулаад хэлэхэд хамгийн харамсалтай нь тэр их хүсэл тэмүүлэлтэй ирсэн залуусын маань 70-80 хувь нь эргээд гадагшаа гарчихлаа. Үлдсэн хэдэн хувь нь гарах арга зам хайгаад, хөөцөлдөөд явж байна шүү дээ. Яагаад гадаадад өндөр боловсрол эзэмшсэн оюунлаг залуус гадаад руу гарахыг тэмүүлэх болов. Үнэхээр Монголд ирээд 2-3 жил амьдрахад л энд болохгүй юм байна гэдгийг мэддэг.

-Монголдоо ажиллаж, амьдрах гэсэн чин хүсэл эрмэлзлэлтэй ирсэн залуус эх орноо орших шалтгаан юу байв?

-Аргагүй шүү дээ. Хийе, бүтээе гэсэн залуусаа төр нь ч, эрх бүхий албан тушаалтнууд нь ч доош нь дараад байгаа юм чинь. Тиймээс л сурч боловсорч, өөрийгөө хөгжүүлсэн оюуны тархи болсон залуусаа алдчихаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, манай улсын улс төр, нийгэм-эдийн засгийн тогтолцоо иргэдэд цааш нь түлхдэг гэсэн үг. Өөр дээрээ жишээ авья л даа. Солонгост байхад янз бүрийн бизнесийн санаа олсон. Түүнийгээ эх орондоо ирээд хэрэгжүүлээд ажил хэрэг болгох гэж үзсэн. Гэтэл манай улсад бизнес эрхлээд, шинэ зүйлийг санаачлаад явъя гэсэн залуусыг дэмждэг тогтолцоо байдаггүй юм билээ. Яах вэ, шударга өрсөлдөөн гэдэг утгаараа тогтолцоо нь байхгүй байж болно. Гэхдээ ядаж шударгаар, цэвэр өрсөлдөх орон зай байх ёстой. Харамсалтай нь, Монголын нийгэмд тэр орон зай ч байдаггүй. Татварын дарамт, мэргэжлийн хяналтын байгууллагаас авахуулаад өчнөөн хүнд сурталтай зүйлс бий. Дээрээс нь шударга бус өрсөлдөөн. Эдгээр зүйлс Монголд маш их газар авсан. Яг ижилхэн гараанаас өрсөлдөх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр залуу бизнес эрхлэгчид ямар нэгэн намыг дагаж, улс төрийн амбийцтай байх ёстой юм байна гэж ойлгодог. Зарим нэг нь тэр чигээрээ улс төрийн тогоонд чанагдана, зарим нь бизнесийн салбартаа үлдж байна. Би бизнесийн салбарыг сонгосон. Үнэхээр улс төрийн салбар дахь будилаан миний хувь хүний үзэл бодолтой таарахгүй юм гэдгийг ойлгосон. Тэр ч утгаараа өөрийнхөө чин хүсэл болох эх орондоо ихийг хийж, бүтээх хүсэл мөрөөдлөө биелүүлэхийн тулд өөрийнхөө хийж чадах боломжит зүйлсийг эрэлхийлж, хайж эхэлсэн. Одоогоор нэг бизнесийн санаа олоод бэлтгэл ажил хангагдаад явж байна.

-Монгол Улсын эдийн засаг доройтсон гол шалтгааныг та хэрхэн харж, дүгнэж байна вэ?

-Энгийнээр ойлгуулахын тулд геополитиктой холбож тайлбарла. Дэлхий дээр аливаа улс, үндэстэн өөрийн ноёрхлоо тогтоож, эзлэн түрэмгийлэх дөрвөн төрлийн арга байдаг. Цэрэг дайны, эдийн засгийн, соёлын, шашны гэсэн дөрвөн төрлийн аргаар ямар нэгэн улс оронд өөрийн ноёрхлоо тогтоож, колони орноо болгодог. Эдгээр аргууд дотроо хатуу, зөөлөн гэж хуваагддаг. Хатуу арга мэдээж, цэрэг дайны хүчээр өөрийнхөө эзэмшлийг тогтоож, колони улсаа болгох орно. Энэ арга одоо ч манай

дэлхий дээр бий. Бидний сайн мэдэх Иран, Ирак, Сири гэх мэтчилэн орнууд өөрсдийн ноёрхлоо тогтоохын тулд үргэлж хоорондоо тэмцэлдэж байна шүү дээ. Харин нөгөө нэг арга нь эдийн засгийн арга. Хэдхэн долоо хоногийн өмнө Хятадууд боомтынхоо үнийг нэмсэн чинь Оюутолгой эзсийн баяжмалаа гаргаж чадахаа больсон талаар мэдээлсэн. Энэ бол тухайн улс үндэстний эдийн засгаар нь дамжуулж эзлэн түрэмгийлэн, өөрийнхөө колони орон болгосны нэг жишээ юм. Тэнд Оросын ч юм уу, Хятадын хил хаагдахад Монгол Улс шууд асуудалд орж эхэлдэг. Эд материалын гачигдалд орно. Тэгээд шашны арга. Энэ түрэмгийлэлд манай улс мөн л өртчихсөн. Хамгийн сүүлийн жишээ гэхэд цахим ертөнцөд "Аав аа, намайг ашиглаач" гэсэн бичлэг тарсан. Хэдийгээр тэр хувь хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийн асуудал ч гэсэн ямар нэг хэмжээгээр улсын үндэсний аюулгүй байдлаа алдагдсаны л тод жишээ. Тэгэхээр шашнаар дамжуулж хүмүүсийн үзэл бодлод нөлөөлж, өөрийн орны ноёрхлоо тогтоож болдог гэсэн үг. Хамгийн сүүлд соёл. Соёлоор дамжуулж эзлэн түрэмгийлдэг. Гудамжинд явж байгаа захын залуугаас чиг солонгос дуу сонсох дуртай юу, кимчи иддэг үү, солонгос олон ангит кино үздэг үү гээд асуу. Тийм ээ. Дуртай л гэж харуула. Яах вэ, магадгүй өөрөө эдгээр зүйлсийн аль нэгэнд нь дургүй байлаа гэхэд гэр бүл дотор нь солонгос кинонд дуртай ээж, Солонгосын оддыг дуурайдга, шүтдэг охин дүү, кимчинд дуртай аав байж байгаа. Энэ бол соёлоор дамжуулж эзлэн түрэмгийлж буй арга. Эхлээд тухайн улс орны иргэдтэй соёлоо ижил болгоно, түүнийгээ дараа тэгж байна. Манай улстай бараг ижил соёлтой гэдэг утгаараа өөрийнхөө улсын нэг хэсэг гэж авч үзэж байх жишээтэй. Үүнийг хэлэхэд, бидний 15 жилийн өмнө мэддэггүй, төсөөлдөг ч үгүй байсан кимчи гэх ялзарсан байцаа чинь монгол айл өрх бүрийн хэрэгтэй боллоод хувирчихлаа, бидний нүдэн дээр. Бид солонгос хоол идэж, солонгос дуу сонсож, солонгос кино үзэж, солонгос хувцас хүртэл өмсдөг болсон байна. Энэ чинь соёлын колони буюу эзлэн түрэмгийлэл байхгүй юу. Тэгвэл Монгол Улс дээрх дөрвөн дайны гуравт нь цэвэр ялагдчихсан байна. Худалдааны буюу эдийн засгийн дайн дотроондоо Монгол Улс ялагдсан. Соёлын болон шашны түрэмгийлэлд өртчихсөн. Ялангуяа худалдааны дайн 100 хувь ялагдал хүлээсэн. Эндээс харахад, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, Тусгаар тогтнол гэдэг зүйл алдагдсан. Бид аль хэдийнэ гадаадын улсын колони болсон. Эдийн засгаараа ч, соёл, шашнаараа ч колони орон болчихоод байна. Яах вэ, нөгөө улс орнууд нь улайм цайм та нар колони болсон гэж дуугарахгүй байгаа болохоор л ард түмний нүд халттай яваад байна л даа. Гэхдээ бидний нүдэн дээр улс, эх орныг минь колони болгож байна. Тиймээс л Монгол Улс эдийн засгийн уналтад орж, одоо болтол сэргээхгүй байгаа юм. Нэг үгээр хэлэхэд, Монгол Улс эдийн засгийн дайн дийлдэж явж байна ард иргэд нь ядуу, зүдүү, боолын хөдөлмөр эрхэлж амьдарч байна. Ерөөсөө л шалтгаан нь тэр. Эдийн засгийн агшинг байдал ч тэр. Дээрээс нь эх орныхоо монгийг шамшигдуулах гэсэн хэдэн

улстөрчтэй. Тэгэхээр улс орон яаж хөгжиж, эдийн засаг сэргэх вэ дээ.

-Бид худалдааны дайнд ялагдаж, колони болсон учраас эдийн засаг сэргээхгүй байна гэлээ. Эдийн засгийн уналтаас гарах боломж байна уу. Яах вэ, Засгийн газар эдийн засгийн уналтаас гаргахын тулд илүүдэл зардлаа багасгаж, төсвөө танах арга хэмжээг авч байна л даа. Гэхдээ та бизнесмэн хүний хувьд хүнд байрлаас гарах гарцыг арай өөрөөр харж байгаа байх?

-Би хувь хүнд юу хийх тухай заах гэхээс илүү өөрөө эх орондоо юу хийх вэ гэдэг талаас нь хардаг. Мэдээж хэрэг, би эдийн засгийн уналтаас гарах арга гээд мянган удаа ярьсан ч миний үгийг Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүд сонсохгүй. Харин Ерөнхий сайдад сонсогдохоор би юу хийж чадах вэ гэдэг чухал. Үнэхээр тийм ажил хийж чадаж байвал улс, эх орноо эдийн засгийн хямралаас гарахад нөлөөлж байгаа том ажил болно. Би одоогийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байрлаас гарахын тулд ямар зүйл хийвэл зүгээр вэ гэж бодсон. Тухайлбал, Монголын эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг харья л даа. Улаанбаатарын гудамжаар нэг KFC, Burger King, Cafe bene гэх мэтчилэн үйлчилгээний газрын салбарууд хаа, сайгүй хаалгаа нээсэн байгаа. Яах вэ, энэ нь хэрэглэгчдэд сонголт олгож буй давуу талтай боловч эсрэгээр нь эдийн засаг талаас хараад үзвэл дотоодын өрсөлдөх чадварыг үгүй хийж байгаа нэг хэлбэр юм. Өнөөдөр таны сарын орлого 200 мянган төгрөг байлаа гэж бодье. Гэтэл таны халааснаас сард 210 мянган төгрөгийн зардал гараад байвал санхүүгийн хувьд оршин тогтноход хэцүү болно. Ингээд л зээл авна, хүүгээ төлнө гээд үргэлжлээд байна. Үүнтэй адилхан гадаадын үйлчилгээний салбар Монголд үүд хаалгаа нээх тусам манай улсын санхүүгийн нөөц шавхагдаад байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, валютын нөөцийг алдагдуулаад байгаа юм. Жишээлэхэд, KFC, Burger King, Сай cafe бээр олон улсын үйлчилгээг Монголоо явуулах зөвхөн эрхийг нь авахын төлөө 100-150 мянган ам.долларыг эх компанид төлдөг. Зөвхөн Монголд оруулж ирэх эрхийг авахын төлөө шүү. Тэгээд болоогүй сар бүрийн ашигынхаа 20-25 хувийг мөн л эх компанидаа тушаана. Гадаадын зах зээл рүү явж байгаа урсгал үүгээр зооцохгүй. Олон компани байгаа болохоор хүмүүсийн сайн мэддэгээр нь KFC дээр л жишээ болгоод ярьчихъя. Түүнээс тэр компанийн үйлчилгээ, үйлчилгээний чанарын талаар яриагүй шүү. Мэдээж, KFC-ийн амттай тахиаг хийхэд туслах материал хэрэгтэй юу, хэрэгтэй. Тэгвэл тэр бүх материалыг тухайн орноос худалдаж авах шаардлагатай байдаг. Амтлагч, кетчуп гэх мэтчилэн KFC гэх бүтээгдэхүүнийг бий болгодог өвөрмөц амтыг эх орондоо мэдрүүлэхийн тулд туслах материалыг худалдаж авах шаардлага гарна шүү дээ. Ингээд бодохоор тэр эх компаниас манай улсад хөрөнгө оруулалт гэж юу орж ирвэ. Зөвхөн манай энэ үйлчилгээг Монголд явуулахыг зөвшөөрч байна гэсэн гэрээний цаас л ирсэн. Оронд нь тэр үйлчилгээг Монголынхоо ард иргэдэд үзүүлэх гэсэн бизнес эрхлэгчдийн хамаг ашиг нь

ЧУХАЛ ХҮН

УЛС ЭДИЙН ЗАСГИЙН ДАЙНД ЯЛАГДСАН УЧРААС ЭД БООЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ БАЙНА

Чиглээний салбарыг ашиглаж, эдийн засгийн уналтаас гарах боломжтой-

гадаад руу гараад явчихдаг. Монголд үлдэж байгаа нь цөөхөн. Бараг дөнгөн данган л ашгаа авч үлдэж байгаа байх, заримдаа ашиггүй ч байгаа. Гэтэл монгол бизнесмэн KFC-ийн үйлчилгээ явуулахын тулд өөрөө үйлчилгээ явуулах байраа гаргана, материалаа худалдаж авна дээрээс нь эх компанид сар бүр орлогынхоо 20-25 хувийг өгч байна. Эндээс бид нэг зүйлийг л ойлгох хэрэгтэй. Чи, бидний уух дуртай, идэх дуртай KFC, Burger King, Cafe bene-гийн нэг ширхэг бүтээгдэхүүн болгон нь нэмэгдсэн өртөг шингэсэн байдлаар Монголын гадаад валютын нөөцөөс их хэмжээгээр гадагшлуулж байна гэдгийг л ойлгогчид. Гол нүх нь болж байдаг гэсэн үг. Тэгээд би эндээс гарцыг олж харсан.

Манай бизнес эрхлэгчид гадаадын үйлчилгээний сүлжээг эх орондоо оруулж ирж байна. Тэд хэрэглэгчдийн сонирхлыг татахуйц шинэ санаа, шинэлэг бүтээгдэхүүнийг олж харж байна уу. Алдсвал хэрэглэгчид өөрсдөө гадаадын эд зүйлийг сайшаадаг, илүү тааламжтай хүлээж авдаг зан дээр нь бизнесмэнууд тоглолт хийгээд байна уу?

Нэгдүгээрт, дотоодын өрсөлдөх чадвар гэдэг зүйл Монголд үнэхээр хэцүү байна. Хүн ам багатай. Дээрээс нь ямар зүйлийг шинээр бий болгоод, цааш нь хөгжүүлээд явахад төрийн дарамт болон нийгмийн дарамт асар их байдаг. Асар их хүч, хөдөлмөр шаардагддаг. Түүний оронд гадаадаас нэг бүтээгдэхүүн импортлоор оруулж ирээд зарчихвал ачаалал, стресс багатай, хамгийн амархан хувилбар. Монголд Сайн bene-тэй ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоё гэвэл асар их цаг хугацаа хэрэгтэй. Нөгөө бичиг баримт цуглуулахаас авахуулаад маш их ажиллагаа, хүч хөдөлмөр шаардагдана. Хэрвээ тэр чинь амжилттай болохгүй бол тухайн бизнес эрхлэгч шууд эрсдэл хүлээнэ. Дампуурна, өрөнд орно. Үүнээс болоод бизнес эрхлэгчид болон худалдаачид их эвчлэн гадаадын орноос бараа, бүтээгдэхүүн оруулж ирж байна. Уг нь үүний эсрэг төрийн бодлого, төрийн пи-ар гэдэг зүйл ажиллаж байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, төрийн пи-арын баг монгол хүний имиж гэж зүйлийг бүрдүүлж байх ёстой байдаг. Өнөөдөр бид, япон хүн гэхээр ямар нэгэн тодотгох бодол төрдөг. Хөдөлмөрч, ажилсаг, цаг барьдаг, тоёото, ниссан гэх мэтчилэн. Америк хүн гэвэл баян чинээлэг, эрх чөлөө, өндөр боловсрол гэх зэргээр тухайн үндэстэн болгоныг тодотгох бодол орж ирдэг. Энэ чинь нэг ёсондоо тухайн улсын төрөөс бодлогоор олон улсад өөрийн орны иргэдийн имижийг бүрдүүлж өгсний шинж шүү дээ. Гэтэл монгол хүн гэхээр хамгийн түрүүнд юу бодогдож байна вэ. Архичин, гуйлгачин, тамхичин, соёлгүй бүдүүлэг, арчаагүй, хариуцлага хүлээдэггүйг эрхлэгчид өөрсөөр имижүүд орж ирдэг. Бодоод үзье л дээ. 800 жилийн өмнө монгол хүний талаарх дэлхийн сэтгэлгээ ийм байсан уу гэвэл үгүй. Хэрвээ ийм байсан бол гудамжны арчаагүй архичин, тамхичин, залхуу эрчүүд яаж дэлхийг эзэлж чадах байсан юм. Чадахгүй шүү дээ. Тэгвэл хамгийн түрүүнд төрийн зүгээс нэгдсэн бодлогоор үндэстний тухай имижийг гадаадын болон дотоодын зах зээл дээр бий болгож өгөх пи-ар үйл

ажиллагааг хийх ёстой байсан юм. Хэрвээ чи монгол хүн бол эх оронч байх ёстой, цаг барьдаг, зарчимч, худал хэлдэггүй байх ёстой гэх мэтчилэн үндэстний имижийг ард иргэдийнхээ сэтгэхүйд суулгаж, гадаадад эергээр таниулах хэрэгтэй. 800 жилийн тэртээх дэлхийг байлдан дагуулж байсан монгол цэргүүд “Бороо орсон ч болзоондоо. Хур орсон ч хугацаандаа” гэсэн хэлц үгийг хоорондоо хэлэлцдэг байсан гэдэг. Жилийн дараа Армины нутгийн тэр нэг уулан дээр 10 мянган цэрэг цуглана шүү гээд цаг товлонд бүтдэд нь зар тараахад, жилийн дараа нэг ч цэрэг хоцрохгүй тэнд очдог байсан. Тухайн үед одоогийнх шиг зам заагч, цаг гэж байх юм биш. Тэгсэн хэрнээ л цуглардаг. Тийм л их хариуцлага байсан, бидний өвөг дээдэс. Одоо бид цагтай, нартай хэмжээтэй, ухаалаг утас барьж байгаа хэрнээ цагаа барьж чаддаггүй. Дахиад нэг жишээ хэлэхэд, Монголчууд Герман хүнээс илүү цаг барьдаг байжээ. Учир нь монгол хүний “За андгай буй за” гэж үг байдаг. Өөрөөр хэлбэл, монгол хүн “За” гэж хэлсэн л бол андгайлсантай эн зэрэгцдэг. Заавал хэлсэндээ хүрдэг. Энэ мэтчилэн эерэг имиж бидэнд байсан. Хамгийн харамсалтай нь сүүлийн 70-80 жилд л монголчууд мах цусанд шингэсэн зан чанараа алдчихлаа. Бид еврейчүүд хүүхэддээ “Чи еврей хүн бол ийм байх ёстой” гэж сургадаг шиг монгол хүүхдийн сургалтын системд оруулж байгаад сургах ёстой юм. Намайг их сургуульд суралцаж байхад хичээл дээр “Төр үндэстний хэмжээний сурталчилгаа явуулж болно” гэж заадаг байсан. Дэлхийн аль ч улс оронд телевизээр нь ард иргэдээ уриалсан, үндэстний имижийг сурталчилсан зар сурталчилгаа явдаг. Монголд тийм сурталчилгаа байна уу. Байхгүй. Бүх нийтийг уриалсан телевизийн сурталчилгааг харсан уу. Телевизээр “Татусгай залгавал хариуцлага хүлээнэ шүү” гэж ярьж байгаа боловч “Та үндэстнийхээ үйлдвэрнийг дэмжвэл ингэх юм байна. Эх орондоо ийм хувь нэмэр оруулна” гэсэн сурталчилгаа явж байна уу. Үнэндээ явахгүй байгаа шүү дээ. Та дотоодод үйлдвэрлэсэн нэг ширхэг балыг худалдаж авснаар эх орондоо ямар хувь нэмэр оруулж, ямар хөрөнгө оруулалт хийж байгааг ойлгуулсан сурталчилгаа Монголын нийгэмд дутагдаж байгаа. Хоосон орон зай байна гэсэн үг. Солонгосын төрөөс клоп урсгалаа хөгжүүлэхийн тулд 100 сая вонн зарцуулсан гэж ярьдаг юм. Монголчууд тэр хэмжээний биш юм гэхэд тал хувьд нь хүрэхүйц мөнгө яагаад зарцуулж болохгүй гэж. Төрийн зүгээс үндэстний үйлдвэрлэлээ дэмжих, монгол хүний имижийг бүрдүүлэх гэдэг асуудлыг бүрэн орхисон. Тиймээс би өөрийнхөө хийж чадах зүйлээ л хийе гэж бодсон юм. Үндэстний брэндийг гаргаж гэж бодсон л доо. Яагаад заавал бид хэдэн зуун мянган ам.доллар төлөөд гадаадын брэндийг хэрэглэх ёстой юм. Бид үндэстнийхээ брэндийг зөрүүлээд гадаадын зах зээлд гаргаж болно шүү дээ.

Нууц биш бол шинэ бизнесийнхээ талаар сонирхуулахгүй юу?

Сүүлийн үед дэлхий нийтийн хандлага аж үйлдвэрийг хөгжүүлэн гэхээс илүү үйлчилгээний салбарыг хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Үйлчилгээний салбарыг тайлбарлахад нэг ёсондоо бид хувцас оёхгүй. Зөвхөн

...Эндээс бид нэг зүйлийг л ойлгох хэрэгтэй. Чи, бидний уух дуртай, идэх дуртай KFC, Burger King, Cafe bene-гийн нэг ширхэг бүтээгдэхүүн болгон нь нэмэгдсэн өртөг шингэсэн байдлаар Монголын гадаад валютын нөөцөөс их хэмжээгээр гадагшуулж байна гэдгийг л ойлгогчид. Гол нүх нь болж байдаг гэсэн үг. Тэгээд би эндээс гарцыг олж харсан...



хувцасны загварыг зохионо. Бид зохиосон юм чинь тухайн загварын эзэмшигч болно. Харин тэр загваруудаа бусад үйлдвэрлэл хөгжсөн Вьетнам, Хятад зэрэг улсын оёдлын үйлдвэрт захиалгаар хийлгэгчид. Тэр л нэг ёсондоо Монголын үндэстний брэнд болж байгаа юм. Би үүнтэй адилхан түргэн хоол, кофе шоппын чиглэлээр үндэстний брэйчээс буюу үйлчилгээний салбарын загварыг гаргахаар зориод жил гаруй хугацаанд ажиллаж байна. Монголоо гэсэн сэтгэлтэй залуучууд, бизнес эрхлэгчид нэгдсэн. Жишээлбэл, манай “Сэлэнгэ пресс” компанийн ерөнхий захирал М.Болд биднийг дэмжин ажиллаж байна. М.Болд захирал маань их тулхтай хүн л дээ. “Сэлэнгэ пресс” компани Монголын хөлбөмбөгийн спортыг 25 жил тасралтгүй ивээн тэтгэж байна. Эрсдэлтэй, алдагдалтай он жилүүддээ ч хөлбөмбөгийн спортын хөгжилд хувь нэмрээ оруулан ивээн тэтгэж ирсэн.

Одоо харин М.Болд захирал маань үндэстний брэндийг гаргаж ирэхэд “Би туршлага болон хөрөнгө оруулалтаар оролцёё. Би дэмжээд өгье” гээд таван чадварлаг залууг цуглуулаад, одоогоор төслийн баг гаргаад ажиллаж байна.

Үндэстний хэмжээний брэндийг гаргаж ирнэ гэхээр сонирхолтой санагдаж байна. Тэр дундаа үйлчилгээний салбарт гэхээр. Товчхондоо, KFC, Burger King зэрэг олон улсын үйлчилгээний сүлжээ шиг компани байгуулна гэж ойлгож болох уу?

Тийм. Манай төслийн багт дэлхийн топ таван дизайнерыг багш нарын тоонд ордог япон багшийн шавь гээд монгол залуу байна. Мөн Бээжин, Шанхай зэрэг олон улсад дээд боловсрол эзэмшсэн мундаг залуучууд бий. Биднийг нэгтгэж байгаа нэг л зүйл гэвэл үндэстний брэндийг дэлхийд гаргах юм. Манай М.Болд захирал ч гэсэн эдийн засаг хүндрэлтэй, хэвлэлийн салбар уналтад орсон үед биднийг дэмжиж, хөрөнгө оруулалт хийсэн нь эх орноо гэсэн сэтгэл харагдаж байгаа юм. Би өмнө хэлсэн. Бид би брэйчээс буюу олон улсын үйлчилгээний салбараас гарцыг харсан гэж. Тэгэхээр бидэнд энэ салбарт сул орон зай, боломж байгаа. Тэгэхдээ түргэн хоол, кофе шоппын чиглэлээр үйл ажиллагаа

Эндээс харахад, бид гадаадын бүтээгдэхүүнийг, гадаадын бизнесмэнуудийг дэмжээд байгаа юм. Гэтэл монгол бизнесмэнууд гадаадын зах зээл дээр гарах гэхээр хаалт маш их. Тухайлбал, япон руу цамц хийгээд гаргая гэхэд Японд үйлдвэрлэгдсэн утсаар оёсон байх ёстой гэсэн шаардлага тавиад эхэлдэг. Хэрэв америкт үйлчилгээний салбар нээе гэвэл тухайн улсын бизнес эрхлэгчээс тав дахин илүү татвар төлөх болдог. Гадаадын улс орнууд энэ мэтчилэн зах зээлээ хамгаалчихсан болохоор хэн дуртай нь үйлчилгээ явуулахад асуудалтай. Харин манай улсад тийм зүйл байхгүй. Тэр солонгос ресторануудын ихэнх нь брэйчээс буюу үйлчилгээний салбарын гишүүд байдаг. Сургууль соёлыг нь төгссөн монгол залуучууд эх орондоо бизнес эрхэллээ гэхэд түүнд ашиглагдах туслал бүтээгдэхүүнийг амтлагчнаас нь эхлээд гаднаас худалдаж авна. Харин бидний хэлээд байгаа ази хоол өөр. Бидний үндэстний брэнд амжилттай ажиллаад тэндээс олсон орлого монгол руу л чиглэгдэж байвал тэр чинь үндэстний брэнд гэсэн үг. Эсрэгээрээ сайхан монгол гэсэн бичигтэй хэрнээ Солонгос юм уу, Хонконгийн бизнесмэний халаас руу ашиг нь ороод байвал тэр чинь гадаадын брэнд. Үндэстний

төлдөг. Дээрээс нь орлогынхоо тодорхой хувийг бас өгнө. Харин бидний олон мянган салбартай гэж ярьдаг ZARA компани загвар зохиосныхоо мөнгийг бизнес эрхлэгчдээс авдаг. Герман ч юм уу, Солонгост ZARA компани дэлгүүр барих шаардлагагүй. Яагаад гэвэл тэдний бүтээлийг зарах эрх авсан бизнесмэн өөрөө барьчихна. Тэгээд ZARA-гийн нэрийн дэлгүүр гээд нэрлэгддэг. Асар их ашигтай ажилладаг. Ийм л салбарт бидэнд орон зай, боломж байна. Энэ салбарт хүч үзэхээр төслийн багийнхантайгаа ажиллаж байна.

Сонирхоодасуухад мэдэж монгол хоол байх нь, тийм үү. Мөн түүний дагаад бусад үндэстний компаниуд хөгжих боломжтой юу?

Тийм. Бид хоолны амт, технологи тал дээр Мастер тогооч нарын холбоотой хамтарч ажиллаж байгаа. Мастер тогооч нарын холбооны тогооч энэ талыг хариуцаж ажиллана. Мэдэж бид үндэстний брэнд учраас бидний үйлчилгээг дагаад Алтан тарианы гурил, монгол малын мах, хүнсний ногоо, давс зэрэг хүнсний худалдаа эрхлэгчид хөгжих боломжтой. Учир нь бид үндэстний брэнд гэж байгаа учраас бүх бүтээгдэхүүнээ Монголоосоо авна. Мөн кофе шопт чинь гэсэн дэлхийд

брэнд гэхээрээ заавал Чингис хааны зурагтай арьсан бүтээгдэхүүн байх албагүй. Дэлхийн хэрэглэгчдийн чиг хандлагыг харж байгаад нэг брэнд бүтээчих. Заавал монгол нэртэй ч байх албагүй. Хамгийн гол нь тэр брэндийг эзэмшигч нь монгол хүн л байхад болно. Хэрвээ тэгвэл гадаадын аль ч улс оронд нээсэн салбарын чинь орлого, мөнгөний урсгал Монгол руу л чиглэж байвал тэр чинь үндэстний брэнд гэж ойлгох хэрэгтэй. Дахиад нэг жишээ аваад хэлэхэд, бидний сайн мэдэх ZARA гэж брэнд байна. Маш олон улсад хэдэн мянган салбартай. Гэхдээ энэ компанид ихдээ л 70-80-аад загвар зохион бүтээгч ажиллаж байгаа. Тэд жил бүрийн хувцасны чиг хандлагыг зохиогоод ямар нэгэн үйлдвэрлэгч орноор хувцсаа оёулдаг. Харин бизнесмэнууд ZARA-гийн загвар зохион бүтээгчдийн зохиосон хувцсыг эх орондоо зарах эрхийг авахын тулд 100-150 мянган ам.доллар

хүлээн зөвшөөрөгдсөн кофе бэлтгэгч хүмүүс ажиллана. Манай улсад энэ чиглэлээр төгссөн залуус байдаг юм билээ. Бид эхний салбараа 2017 оны нэгдүгээр сард нээхээр төлөвлөсөн. Байрны маань интерьер дизайнерын ажил явагдаж байна. Ерөнхийдөө төсөл дуусах шатандаа орсон. Хэрвээ энэ брэнд амжилттай явж чадах юм бол Монголын үндэстний үйлдвэрлэгч Алтан тарианы гурил зэрэг дээр хэлсэнчлэн бүтээгдэхүүнүүд дэлхийн зах зээл дээр гарах боломжтой. Кофе нь хүртэл Монголынх байх юм. Манай кофе шоппын залуу Итоп, Бразил зэрэг кофе тариалдаг орнуудтай гэрээ хийсэн. Тэндээс кофегоо оруулж ирээд өөрөө хуураад бэлтгээд нэмүү өртгөө шингээгээд зарна гэсэн үг. Цаашид бидний бүх салбарыг кофегоор хангаж ажиллах юм. Нэг үгээр хэлбэл, нэмүү өртөг шингэсэн бүх бүтээгдэхүүн Монголд л байна гэж ойлгох хэрэгтэй.

УЛС ТӨР

ЗАСГИЙН ГАЗАР

50 ОРТОЙ ХҮҮХДИЙН ТУСГАЙ ТАСГИЙГ ТҮР НЭЭХЭЭР БОЛОВ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИЛН

Ж.ОТГОН

Нийслэлийн хэмжээнд ханиад томуу ихэсч, эмнэлгийн ачаалал хэтэрч байгаагай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүргийн дагуу БХЯ-ныхан Цэргийн төв эмнэлэгтээ Хүүхдийн түр тасга нээн ажиллуулахаар болжээ. 50 ор бүхий тасгийн үзсэн байна. Тасгийг 2017 оны нэгдүгээр сарын 01-нээс өмнө нээж, үйл ажиллагааг нь эхлүүлэхээр болжээ.

Эмнэлэг бус, цагдаагийн байгууллага албадан эрүүлжүүлэнэ

Мөн Засгийн газрын өчигдрийн хуралдаанаар Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Төсөлд, согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг эмнэлгийн байгууллагад /эмнэлэгт/ албадан эрүүлжүүлж байгааг өөрчилж, энэ үйл ажиллагааг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяалалд шилжүүлэхээр тусгажээ. Архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж өөрийгөө хянах чадваргүй болсон этгээдийг эмнэлгийн байгууллагад албадан эрүүлжүүлэх нь иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах нийтлэг эрх ашгийг зөрчиж байна гэж төсөл санаачлагчид үзсэн байна.

Өмчийн үзлэг, тоолого явуулж дууслаа

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тоологын дүнг хэлэлцээд цаашид авах арга хэмжээний

тухай тогтоол гаргахаар болов. ОХУ-ын Москва хот дахь Элчин сайдын яамны II байр, Улаан-Үд хот дахь Консулын газрын барилгад хөрөнгө оруулсан маргаантай асуудал, Монгол Улсаас Бельгийн Вант Улсад суугаа Элчин сайдын яамыг нүүлгэн шилжүүлэх зэрэг асуудлыг судлан, тулгамдсан асуудал, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг холбогдох сайд, агентлагийн дарга нарт даалгав. Мөн төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тоологын дүнг УИХ-д танилцуулахаар боллоо. Тоологод төрийн 1128, орон нутгийн өмчийн 4958 нэгж, хуулийн этгээд хамрагдсан байна. Танилцуулгаас үзвэл үзлэг, тоологод 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа тасалбар болгосон 30 их наяд 74 тэрбум 900 сая төгрөгийн хөрөнгө хамрагдсанаас 17 их наяд 150 тэрбум, 900 сая төгрөгийн төрийн болон орон нутгийн өмчийн өөрийн хөрөнгө байна. Үзлэг, тоологтой холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах, үл хөдлөх хөрөнгөд дахин үнэлгээ хийх, концессын гэрээгээр барьсан барилга, зам, гүүр, тоног төхөөрөмж зэргийг төрийн өмчийн бүртгэлд тусгах зэргийг холбогдох сайд, удирдах албан тушаалтнуудад үүрэг болголоо.

Гадаадын хөрөнгө оруулалттай банк хадгаламж татахгүй

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцээд Засгийн газрын гишүүдийн саналыг тусган Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгчид

...Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов. Төсөлд, согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг эмнэлгийн байгууллагад /эмнэлэгт/ албадан эрүүлжүүлж байгааг өөрчилж, энэ үйл ажиллагааг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяалалд шилжүүлэхээр тусгажээ...

зөвлөлөө. Төсөлд гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбарыг Монгол Улсад нээх, үйл ажиллагааных нь чиглэл, хүлээх үүрэг, хариуцлагыг тусгажээ. Түүнчлэн улс орны нийгэм, эдийн засагт ач холбогдол бүхий үр өгөөжтэй томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, барьцаалах, батлан даах зэрэг харилцааг энэ хуулиар зохицуулах юм. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалттай банк нь хадгаламж тусгахгүй, иргэдийн банкны чиглэлээр үйл ажиллагаа явуулахгүй байх, зах зээл дээр өрсөлдөөнийг хязгаарлах болон давамгайл байдал үүсгэхийг хориглохоор төсөлд тусгажээ.

“Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төсөл хэрэгжүүлэнэ

2013-2016 онд “Гудамж” төсөл хэрэгжиж дуусах шатандаа байгаа учир төслийг татан буулгаж, “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төсөлд шилжүүлэн үлдсэн ажлыг нь гүйцэтгүүлэхээр боллоо. “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн хүрээнд “Хилийн боомт”, “Аймгийн төв”, “Гудамж” гэсэн гурван дэд төслийг хэрэгжүүлэх юм. “Хилийн боомт” дэд төслийн дагуу хилийн боомтуудыг хөгжүүлэхэд цагаанцаа, мастер төлөвлөгөө боловсруулах, шалган нэвтрүүлэх хэсгийн нарийвчилсан төлөвлөлт

үүсвэрээс санхүүжүүлэхээр тооцожээ.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2017 оны хэмжээг тогтоов

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2017 оны хэмжээг тогтоов

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.1-д заасан ажилтны сард төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг түүний сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дөрвөн хувь, үүнээс ажил олгогч хоёр хувь, ажилтан хоёр хувь байхаар тогтоолоо. Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч болон 0-18 насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 2400, хувнараа хөдөлмөр эрхлэгч, малчин, гадаадын иргэн, харьяалаггүй хүн, тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, хүүхдээ хоёр /ихэр бол гурав/ нас хүртэл өсгөн бойжуулж байгаа эх, эцэг, хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.12-т заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 4800 төгрөгөөр тогтоов.

Гэр бүлийн боловсрол олгох замаар хүчирхийллийг бууруулна

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг хэлэлцэндэмжиж, үзэл баримтлалыг баталж, хуулийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг холбогдох сайд нарт даалгалаа.

Хуулийн төсөлд:

Гэр бүл, эцэг, эх, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахыг хуулийн нэг зорилго болгож, төрөөс гэр

бүлийг дэмжих Гэр бүл тогтвортой байх, хүүхэд гэр бүлийн орчинд өсч хүмүүжих, гэр бүлийн хүчирхийлэл буурахад нөлөөлөх гол хүчин зүйл болох гэр бүлийн боловсрол олгох Хүүхдийн төлөө эцэг, эх, асран хамгаалагчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, эцэг, эх салсны дараа хүүлэх үүрэг, хариуцлагыг хэвээр байлгах Хүүхдийн өмчлөх эрхийг хуульчлах Хүүхдийн тэтгэлэг заавал төлөгддөг нөхцлийг бүрдүүлэх, хүүхдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй тэтгэлгийн сан байгуулж, үл маргаж журмаар тэтгэлэг гаргуулах Гадаадын харьяат гэр бүлд хүүхэд үрчлэх асуудал журмаар зохицуулагдаж байгааг өөрчилж хуульчлах, үрчилсний дараах хяналтын бий болгохоор төлөвлөжээ.

Хууль батлагдсанаар гэр бүлийг дэмжих төрийн бодлого, гэр бүлийн боловсрол олгох тогтолцоо бий болж, гэр бүл баг бэх байж, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл цуцлалт буурагтаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам үзэж байна.

Зүүнбаян-Ханги чиглэлд төмөр зам барина

“Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам барьж байгуулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлэхээр болов. Энэ төмөр замаар голлон төмрийн хүдэр тээвэрлэх хэдий ч тодорхой хэмжээний бусад түүхий эд, бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх боломжтой гэж үзжээ. 2018-2025 онд жилд тээвэрлэх ачааны хэмжээг 10-21 сая тонн, 2026-2046 онд 21 сая тонн гэж үзвэл дээрх чиглэлийн төмөр замаар тээвэрлэх ачааны доод хэмжээ дунджаар 15 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Тавантолгойн асуудлаар асуулга тавьжээ

УИХ-ын гишүүн Л.Энхболд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбагд Тавантолгойн бүлэг ордтой холбоотой асуулга тавьжээ. Тэрбээр Монгол Улсын эдийн засгийн хүндрэлээс богино хугацаанд гаргахуйц цаашлаад Монгол Улсыг хэдэн үеэр нь авч явах бүрэн боломжтой “Ард түмний өмч” болсон Тавантолгойн бүлэг ордны талаар Монгол Улсын Засгийн газраас ямар бодлого барьж байгаа, цаашид эдийн засгийг үр өгөөжтэй байлгах ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар асуулга тавьж байгаа аж.

Асуулгад “Эрдэнэс Тавантолгой” ТӨХК-ийн өнөөгийн нөхцөл байдал, тус компанийн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, БНХАУ-ын “Чалко” компанид төлөх өрийн үлдэгдэл,

хэзээ төлөгдөж дуусах, Тавантолгойн энэ ордын өнөөгийн үнэлгээг бодитойгоор тогтоосон эсэх, Монгол Улсын иргэн бүрийн 1072 ширхэг хувьцаа хэзээ бодит үр шимээ өгч эхлэх, үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар, “Эрдэнэс Тавантолгой” ТӨХК-ийн тодорхой хувийг ямар компанид худалдан борлуулах гэж байгаа, манай улсад ямар санал ирсэн, энэ гэрээ хэлцэлд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаа талаар зэрэг асуудалд Монгол Улсын Засгийн газраас үнэн бодитой мэдээллийг ард түмэндээ өгөх шаардлагатай байна” гэжээ. Асуулгын хариуг бичгээр ирүүлж, улмаар УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсохыг хүссэн байна.

Тусгаар тогтнолын асуудлаар чууллаа

“Монгол Улсын тусгаар тогтнол ба батлан хамгаалах бодлого” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд боллоо. Монгол Улс Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 105 жилийн ойг энэ сарын 29-нд тэмдэглэхтэй холбогдуулж уг бага хурлыг ЕТГ, БХЯ хамтран зохион байгуулж байгаа юм. Эрдэм шинжилгээний бага хурлыг нээж ЕТГ-ын дарга Ц.Баярсайхан “Монголчууд эдүгээгээс 105 жилийн тэртээ цагагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9-ний өдөр төр улсын бүх бодлого, үйл ажиллагааг тусгаарлан сэргээсэн Азийн анхны улс болсон онцлогтой. Тэр түүхэн цаг үеэс хойш манай батлан хамгаалах бодлого Монгол төрийн байнгын түшиг, соргог манаа нь болж үеийн үед энэ үүргээ амжилттай

гүйцэтгэж ирсэн, уламжлалт бодлогын нэг байсаар иржээ. Өнөөдрийн зохион байгуулж буй “Тусгаар тогтнол ба батлан хамгаалах бодлого” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын зорилго бол туулж өнгөрүүлсэн түүхээ эргэн харах, одоо болоод ирээдүйд Монгол Улсын тусгаар тогтнолыг эрхэмлэн авч явах гарц, шийдлийн талаар эрдэмтэн судлаачдын саналыг өргөн олонд хүргэх, эх түүхээ хойч үедээ сурталчлан таниулахад чиглэж байгаа юм” гэлээ.

Тус хурлаар “XX зууны Монголын геополитикийн орчин”, “Тусгаар тогтнолын үнэ цэнэ, батлан хамгаалах бодлогын ач холбогдол”, “Тусгаар тогтнолоо сэргээн мандуулж, улсын хил тогтоосны ач холбогдол” зэрэг сонирхолтой сэдвээр эрдэмтэд, судлаачид илтгэл тавилаа.

ДЭЛХИЙ

БНХАУ Нэгдсэн улсын шумбагч аппаратыг эргүүлэн өгчээ

Өмнөд Хятадын тэнгис дэх АНУ-ын цэргийн зориулалттай хүнгүй шумбагч аппаратыг БНХАУ-ын тал булаан авсан талаар бид өмнө нь мэдээлж байсан. АНУ-ын Батлан хамгаалах яамнаас мэдээлснээр шумбагч аппаратыг энэ сарын 15-ны өдрийн шөнө Филиппиний Субик Бей боомтоос баруун хойш ойролцоогоор 90 км зайтай далайн эргээс БНХАУ-ын тал булаан авсан байдаг. Улмаар хууль бусаар булаан авсан шумбагч аппаратыг даруй буцаан өгөхийг тус улс БНХАУ-ын Засгийн газраас шаардаж байсан удаатай. Харин үүний хариуд БНХАУ-ын Батлан хамгаалах яамнаас мөн мэдэгдэл хийж, шумбагч аппаратыг зохих журмын дагуу буцааж өгнө гэдгээ илэрхийлж, АНУ-ын тал жижиг хэргийг томоохон дуулиан болгож буйг шүүмжилсэн юм. Тэгвэл энэ даваа гарагт

Нэгдсэн улсын шумбагч аппаратыг эргүүлэн өгчээ. Хятадын Батлан хамгаалах яамнаас албан ёсны вэб хуудастаа богино хэмжээний мэдэгдлийг тавьсан байсан бөгөөд түүнд “Хоёр улсын тал нөхөрсөг уулзалт хийсний дүнд хүнгүй шумбагч аппаратыг эргүүлэн өгөх ажиллагаа ямар нэг саадгүй амжилттай дууслаа” гэсэн байжээ.

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп сонгогдсоноос хойш хоёр улсын харилцаа хүйтэрч эхэлсэн төдийгүй энэ удаагийн хэрэг ч томоохон асуудал үүсгэж байсан юм. Учир нь Доналд Трамп ялалт байгуулсныхаа дараа БНХАУ-ын “Нэг Хятад” бодлогыг үл тоомсорлон Тайванийн Ерөнхийлөгчтэй утсаар шууд ярьсан байдаг. Үүнээс гадна АНУ-ын “Фокс ньос” телевизийн

нэвтрүүлэгт оролцохдоо сэтгүүлчийн “Нэг Хятад” бодлогыг АНУ цаашид дэмжих үү” гэх асуултад “Бээжин худалдаа болон бас бус асуудалд буулт хийж, найр тавихгүй юм бол заавал тэдний бодлогыг дэмжиж хэрэг байна уу” хэмээн эргэлзсэн өнгө аястайгаар хариулсан юм. Тэрбээр энэ үгээрээ Хятад худалдаа, гадаад худалдааны бодлогодоо буулт хийхгүй бол АНУ “Нэг Хятад” бодлогыг дэмжихгүй байж болногх санааг илэрхийлсэн нь БНХАУ-ын талыг бухимдуулж, тус улсын Гадаад хэргийн яамнаас хүртэл мэдэгдэл гаргасан удаатай. Тэгвэл ийнхүү үл ойлголцол үүссэн хоёр улсын харилцаанд дахин цав суулгаж болзошгүй үйл явдал болсон нь шумбагч аппаратын асуудал байлаа. Ямартай ч, тус аппаратыг эргүүлэн өгснөөр дуулиан шуугиан намжиж байна.



Бан Ги Мун БНСУ-ыг удирдах уу

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албыг хаших хугацаа нь энэ сараар дуусгавар болж буй Бан Ги Мун албан тушаалаа өгснийхөө дараа БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж магадгүй гэнэ. Тэрбээр мягмар гарагт “Эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө би өөрийгөө бүрэн зориулахад бэлэн” гэж хэлсэн аж. Түүний эл үгийг шинжээчид ирэх онд болох Өмнөд Солонгосын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж магадгүй гэсэн үг хэмээн дүгнэж байна. “НҮБ-ыг удирдах 10 жилийн хугацаанд миний сурсан, харсан, мэдэрсэн бүх зүйл БНСУ-ыг хөгжүүлэхэд тус нэмэр болно гэдэгт би итгэлтэй байна. Би энэ улс орныхоо төлөө өөрийгөө зориулах болно” гэж Бан Ги Мун Нью-Йорк хотод Өмнөд Солонгосын сэтгүүлчидтэй уулзах үеэрээ хэлжээ. Өмнө нь БНСУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан тэрбээр ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эсэхээ яг тодорхой хэлээгүй байна. Ажиглагчдын үзэж байгаагаар, тэрбээр энэ оны эцсээр НҮБ-ын тэргүүний албан тушаалаа өгснийхөө дараа улстөрд орж магадгүй аж. Тэрбээр 2007 оноос хойш НҮБ-ыг удирдаж байгаа юм.

ХЯТАДАД ГАДАА ШАЛГАЛТ АВСАН БАГШИЙГ АЖЛААС НЬ ХАЛЖ БАЙНА



...Хятадын нийт 24 хотод агаарын бохирдол онцгой ихэссэнийг сэрэмжлүүлэх улаан дохиоллыг асаагаад байгаа юм...

Хятадын агаарын бохирдлын гол ялгаруулагч нь автомашинууд, нүүрсний станциуд байдаг аж. Тодруулбал, тус улсын хэд хэдэн хотод өтгөн утаа үүсч, улмаар үзэгдэх орчин хязгаарлагдан, зам тээврийн нөхцөл байдал ч хүндэрчээ. Хэбэй мужид гэхэд өтгөн утааны улмаас үзэгдэх орчин 200 метрээр хязгаарлагдаж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор замын хөдөлгөөнийг түр хааж, үд дунд утаа бага зэрэг саарах үеэр хөдөлгөөнийг эргэн нээсэн байна. Ийнхүү утааны асуудалтай нүүр тулсан Хятадын хүрээлэн буй орчныг хамгаалах яамнаас нөхцөл байдал хүндэрсэн зургаан муж руу шинжилгээний 13 багийг илгээжээ. Эдгээр мужид Бээжин, Тяньжин, Хэбэй, Шаньси, Шандон, Хэнан муж багтаж байна.

Албаны эх сурвалжийн мэдээлж байгаагаар Хятадын нийт 23 хотод агаарын чанар маш муу буюу сэрэмжлүүлгийн улаан дохиоллыг асаасан байна. Иймд барилгын ажлуудыг түр хугацаанд зогсоож, цэцэрлэг, бага сургуулиудын хичээлийг амрааж, утаанд нөлөөлж байгаа үйлдвэрүүдийн үйл ажиллагааг

хэсэгчлэн зогсоох зэрэг арга хэмжээнүүдийг авч эхлээд байна. Мөн Бээжин хотын олон улсын нисэх онгоцны буудалд өчигдөр 169 нислэг цуцлагджээ. Энэ нь "Шоуду" нисэх онгоцны буудлын орчимд утаа ихтэй байсантай холбоотой юм байна. Нисэх буудлын захиргаанаас мэдээлж байгаагаар нислэг нь хойшлогдсон зорчигчдод халуун хоол, цайгаар үйлчилж, цаг алдалгүйгээр нислэгийн хуваарьт орж байгаа өөрчлөлтүүдийн талаар мэдээлж буй юм байна. Хятадын нийт 24 хотод агаарын бохирдол онцгой ихэссэнийг сэрэмжлүүлэх улаан дохиоллыг асаагаад байгаа юм. Тэгвэл утааны улирал эхэлсэн байхад сургуулийн гаднах талбайд 400 гаруй сурагчдыг зэргэцүүлэн суулгаж, шалгалт авсан хэрэг мөн гарсан байна. Улмаар орон нутгийн удирдлагууд тус дунд сургуулийн захирлыг албан тушаалаас нь түдгэлзүүлжээ.

Энэ хэрэг Хэнан мужид болсон гэнэ. Тус мужийн удирдлагууд агаарын бохирдлын хэмжээ ноцтой төвшнийг зааж буйтай холбоотойгоор бүх сургуулийг амраах шийдвэрийг гаргасан аж.

Гэтэл нэгэн дунд сургууль уг шийдвэрийг үл тоож, 400 гаруй сурагчдаа гаднах биеийн тамирын талбайд тусгайлан зассан ширээн дээр суулгаж, шалгалт авсан зөрчил илэрчээ. БНХАУ-ын сургуулиуд хүүхдүүдийг нэг нэгнээсээ хуулах, багш нараа хуурч мэхлэх зэрэг үйл ажиллагаанаас сэргийлэх үүднээс биеийн тамирын талбайг ширээнүүдийг хол хол зайтай байрлуулан сурагчдыг суулгаж, шалгалт авдаг аж. Хэдий утааны улирал эхэлсэн ч тус сургуулийнхан энэ уламжлалаа зогсоогоогүй байна. Гэвч орон нутгийн хэвлэл мэдээллийнхэн саарал утаан дунд шалгалтаа өгч буй сургуулийн сурагчдын цацсанаар мужийн удирдлагын чихэнд хүрчээ. Ингэснээр дунд сургуулийн захирал ажлаасаа халагдаж, хэргийг шалгахар шийдвэрлэсэн байна. Тэгвэл энэ мэдээлэл цахим ертөнцөд цацагдаж эхэлхэд, “Сургуулийн захирал асуудалтай, гэхдээ агаарын бохирдол түүнээс ч илүү хортой” гэсэн сэтгэгдэл ч хөвөрч буй гэнэ.

Чой Сун Шилийн охиныг баривчлах тушаал гарчээ

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хегийн дотны найз Чой Сун Шил авлигын хэрэгт сэжиглэгдсэнээс хойш тус улсын улс төрийн салбарт эмх замбараагүй байдал үүссэн билээ. Чой Сун Шилийн Ерөнхийлөгчтэй дотно байдалаа ашиглан томоохон корпорациудаас өөрийн байгуулсан сандаа их хэмжээний мөнгийг хандив нэрийдлээр авч байсан нь илэрсэний зэрэгцээ Ерөнхийлөгч Пак улс төрийн чухал баримт бичгийг найздаа дамжуулж, хэлэх үгээ зааварлуулж байсан нь баримттайгаар илэрсэн. Үүний дараа Ерөнхийлөгч өөрийн биеэр ард иргэддээ хандсан гурван удаагийн мэдэгдэл хийж, толгой бөхийлгөн уучлал хүссэн ч, тусыг эс олсон юм. Пакын нэр холбогдсон дуулианыг сөрөг хүчнийхэн ч ашиглаж, өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа буухыг Ерөнхийлөгчөөс шаардаж, олон тооны ард иргэдийг хамарсан эсэргүүцлийн жагсаалыг зохион байгуулсан байдаг.

Мөн Пак Гын Хед итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулах үндэслэлийг парламентад өргөн барьсан удаатай. Харин Ерөнхийлөгч

өөрийнх нь хувь заяа хэрхэгийг парламентын гишүүдэд даалгасан ч, тэдний ихэнх нь эсрэг сонголтыг хийснээр Пак суудлаасаа бууж магадгүй болсон билээ. Түүнийг албан тушаалаас нь бүр мөсөн огцруулах асуудлыг 180 хоногт багтаан Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэх учиртай.

Тэгвэл саяхан Чой Сун Шилд холбогдох хэргийн анхны шүүх хурал болсны дараа түүний охиныг баривчлах тушаал гарчээ. Хэргийг мөрдөн шалгах тусгай баг Сөүл хотод байрлах Чой Сун Шилийн сангийн байруудад нэгжлэг хийж эхэлснээс гадна эдүгээ Германд амьдарч буй Чойн охин Чён Юраг ч гэсэн албан тушаалаа урвуулан ашигласан гэх хэрэгт сэжиглэж, баривчлах тушаал гарсан байна. Энэ хүрээнд Германы цагдаагийн газарт мэдэгдэл хүргүүлж, Чён Юрагийн байгаа газрыг тодорхойлох, баривчлах, эрэн хайх ажиллагаанд хамтарч ажиллахыг хүссэн аж. Чой Сун Шил болон түүний охин Чён Юра нар өнгөрсөн жил Самсунг группээс их хэмжээний санхүүжилтийг хандив нэрийдлээр авсан нь тодорхой болсон гэнэ.

Б.ДАВААХҮҮ

Агаарын бохирдлын хэмжээ хүний эрүүл мэндэд ноцтой аюул учруулахаар төвшнийг зааж буйтай холбогдуулан БНХАУ-ын Засгийн газраас зарим сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаанд зогсоож, утаа их гаргадаг үйлдвэрүүдийг хааж, барилгын ажлыг хүртэл түр зогсоожээ. Бээжин хотод л гэхэд гурван өдөр сургууль, цэцэрлэгийг хаах арга хэмжээ авсан байна.

SODON

cleaning service

БҮХ ТӨРЛИЙН ЦОГЦ ЦЭВЭРЛЭГЭЭ

АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Ух цэвэрлэгээ
- Гэрээт цэвэрлэгээ
- Гадна срасадны цэвэрлэгээ
- Гадна талбайн цэвэрлэгээ
- Барилгын болон засварын дараах цэвэрлэгээ
- Үдэшилэг хүлээн авалтын дараах цэвэрлэгээ

АЙЛ ӨРХИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Ух цэвэрлэгээ
- Энгийн цэвэрлэгээ
- Хэсэгчилсэн цэвэрлэгээ
- Цонх тагтны цэвэрлэгээ
- Цонх тагтны засвар үйлчилгээ
- Хивс, хивсэнцэр цэвэрлэгээ

УТАС: 95018180, 88120500, 99003618

FACEBOOK: SODON SERVICE

ЦАГ ҮЕ



Аймаас мэдээлж байна

ХЭНТИЙ АЙМАГ

ТОСК-ИЙН БАЙР АШИГЛАЛТАД ОРЛОО



Засгийн газрын аймаг бүрт 1000 Айл орон сууц хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн Чингис хотод баригдсан "Шинэ Өндөрхаан хороолол"-ын эхний ээлжийн 120 айлын орон сууцны барилга ашиглалтанд орж, энэ сарын 16-ны билэгт сайн өдөр нээлтээ хийлээ. Нээлтийн ёслолд УИХ-ын гишүүн Д.Гантулга, ТОСК-ийн Ерөнхий захирал Ж.Хичээнгүй, Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямба, аймгийн ИТХ-ын дарга Л.Батсайхан болон аймгийн удирдлагууд оролцож

нээлтийн тууз хайчилсан бөгөөд хоёр иргэн байрныхаа түлхүүрийг гардан авсан юм. Тус орон сууцны хорооллын барилга угсралтын ажлыг 6.0 тэрбум төгрөгний өртөгтэйгөөр "Дүрт Уул" ХХК хийж гүйцэтгэж, гэрээт хугацаандаа хүлээлгэн өгөөд байна. 2012 онд шавгаа тавьсан энэхүү барилга цахилгааны шугам сүлжээний асуудлаас болоод түр зогсоод байсан юм. Энэ тухай аймгийн удирдлагууд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатад

хүсэлт тавьсны дагуу сайдын нөөц хөрөнгөнөөс 350 сая төгрөг шийдүүлснээр дүн өвлөөс өмнө тус орон сууцны барилга ашиглалтад орох боломжоор хангагдсан билээ. Төрийн орон сууцны корпораци нь аймаг орон нутгийн бүтээн байгуулалтын ажлыг дэмжих зорилгоор өнгөрсөн хугацаанд Хэнтий аймгийн Чингис хотод Засгийн газрын "4000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Тэмүүжин хорооллын гаднах инженерийн шугам сүлжээний холболтын ажлуудыг хийсэн юм.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

Дархан хот "Өвлийн хүлэмж"-тэй болно

Дархан-Уул аймгийн Засаг дарга С.Насанбат, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Баясгалан, Захирагчийн албаны дарга Э.Равжаадэлгэрэх нар аймгийн НААҮГ-ын ажилтай танилцаж тус газарт тулгамдсан зарим асуудлыг шийдвэрлэв. Тус газар нь Дархан хотын хоёр Дарханыг холбосон "Аюулгүйн тойрог"-оос 16 давхар орон сууц, тус орон сууцаас "Үйлчилгээний төв" хүртэлх 2616 м авто замын тусгаарлах зурвасыг хийх, хотын доторх төв зам дагуух хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх боломжтой болох ажээ. Аймгийн НААҮГ-ын дарга Ж.Дорждэрэм "Манай аймагт 2015 онд амьсгалын замын харшлын чанартай нийт өвчлөлийн 62,5 хувь нь ургамлын гаралтай харшил

байсан. Тиймээс манайх шарилжийг ургахаас нь өмнө хор цацаж устгах төлөвлөгөө гаргасан. Ургасан хойно нь биш ургахаас нь өмнө шарилжийг хор цацаж устгах шаардлагатай ч зарцуулах хөрөнгө дутагддаг" гэв. Эдгээр саналыг аймгийн Засаг дарга дэмжиж шаардлагатай төсвийг гаргаж өгөхөөр шийдвэрлэсэн. Мөн өвлийн хүлэмжтэй болж мод бутгаа өөрсдөө тарин гаднаас худалдаж авахын тулд илүү зардал гаргахгүй байхад дэмжлэг хүссэнд аймаг шаардлагатай нийт төсвийн 50-60 хувийг нь олгохоор болов. Аймгийн Засаг дарга мөн үеэр тус газрын удирдлагуудад цаг наргүй ажилладаг зам талбайн үйлчлэгчдийнхээ ар гэрт анхаарал хандуулж, хүүхэд багачуудыг нь секц, дугуйланд хамруулж нийгмийн асуудалд нь анхаарч, амралтын өдрөөр нь үзлэг шинжилгээнд оруулах зэргээр санаачилгатай ажиллахыг үүрэг болголоо.

"Аюулгүй хүнс" аяныг эрчимжүүлнэ

Дархан-Уул аймгийн МХГ-аас шинэ жилийн баяр болох гэж байгаатай холбогдуулах "Аюулгүй хүнс" сарын аяны хүрээнд зургаан дэд бүлэг, 18 заалт бүхий төлөвлөгөө гарган ажиллаж байна. Хүнсний үйлдвэрлэлийг шинээр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг бүртгэлд хамруулахаар төлөвлөжээ. Мөн иргэдээс хүнсний чиглэлээр санал хүсэлт, гомдол мэдээлэл хүлээн авч барагдуулах. Хүнсний зах худалдааны төвүүд, мах, махан болон кремт бүтээгдэхүүний цех, хүлээн авалт зохион байгуулдаг хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрууд Цэцэрлэгийн хүүхдийн хоолонд хэрэглэдэг мах, худалдаалагдаж буй савласан бэлэг, согтууруулах ундаа, пиротехникийн хэрэгслийн худалдаа зэргийн баталгаажилтын байдалд энэ сарыг дуустал хяналт шалгалт хийнэ. Шалгалтын явцад бүх төрлийн хуванцар савны хэрэглээ, хүнсний түүхийн эд, бүтээгдэхүүний шошгын зөрчлийг судална. Урьдчилан сэргийлэх шалгалтыг найман улсын байцаагч хамтарсан байдлаар, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийхээр боллоо гэж аймгийн МХГ-аас мэдээллээ.

БУЛГАН АЙМАГ

Хоёр жилийн дараа Спортын ордон ашиглалтад дахин орно

Булган аймгийн Спортын ордонд үйл ажиллагаа явуулах боломжгүй болоод байна. 2011 онд 1 тэрбум 400 орчим сая төгрөгөөр босч байсан тус Спортын ордон зун болохоор борооны ус нэвт гоожиж, өвөлдөө тэрхүү шүүрэн шанага шиг болсон дэвэрээрээ дулаан алдаж дотор нь ямар ч бэлтгэл, уралдаан тэмцээн зохион байгуулах боломж бүрдэхээ болиод байна. П.Мэндбаяр захиралтай "Авзага трейд" ХХК Спортын ордныг барьж улсын комисст хүлээлгэн өгч байсан бөгөөд, чанаргүй

барилга хүлээн авсан улсын комисс харнуцлага хүлээх үү, П.Мэндбаяр хариуцлага хүлээх үү гэдэг нь тодорхойгүй байна. Барилгын ажлыг гүйцэтгэгч компани руу орон нутгийн зүгээс албан бичиг хүргүүлэхэд нааштай хариу өгөөгүй байна. Тиймээс ирэх 2017 онд Спортын ордны барилгын засварын зураг төсвийг хийлгэж, 2018 оны төсөвт засварын ажлыг хийх төсвийг суулгаснаар тус спортын ордон ашиглалтад орно. Өөрөөр хэлбэл 2 жилийн дараа Спортын ордон ашиглаж болох нь ээ.

Ирэх онд 3 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хийнэ

Булган аймгийн 80 жилийн ойг угтан 3 тэрбум орчим төгрөгийн бүтээн байгуулалтын ажлыг 2017 онд хийхээр төсөвлөвөө. 80 бүтээлч ажил хийхээр төлөвлөснөөс ихэнх нь буюу 90 хувь нь Булган аймгийн төв Булган суманд хийнэ. Аймгийн төв замыг өргөтгөх, гэрэлтүүлгийг бүрэн гүйцэтгэж, ногоон байгууламжийн хашаа хайсыг сайжруулах, наадмын талбайг шинэчлэх, үерийн усыг зайлуулах сувгийг нэмэх зэрэг ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж юм байна. Мөн үүний зэрэгцээ хандив тусламжаар ч хийх ажлууд байгаа бөгөөд, аймаг руу ордог 2 том шинэ хаалга, гүүрүүдийг барина. Яг 80 жилийн ойд нийтдээ хичнээн тэрбум төгрөг зарцуулагдах нь одоогоор тодорхойгүй байна. Мэдээллийг аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий өглөө.

Хүчингүйд тооцов

"Монгол Суу Ухаан" академийн 8000123 тоот гэрчилгээний дугаартай улсын бүртгэлийн дугаартай гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

"Галтчимэг" констрашн ХХК-ийн 6051642 регистртэй, Улсын бүртгэлийн дүрмийн сангийн хамт гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Мотоцикльтой замын хөдөлгөөнд оролцохыг хориглолоо

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, иргэдийн амь насыг хамгаалах зорилгоор төвийн засмал замуудаар мотоцикльтой зорчихыг хориглосон байна. Бичиг баримтгүй буюу замын хөдөлгөөний дүрэм мэдэхгүй

иргэд мотоцикльтой замын хөдөлгөөнд оролцсоноор унаж бэртэх, нас барах зэргээр осол гэмтлийн тоо төдийлөн буурахгүй байгаа юм. Тиймээс Арвайхээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 11-р сарын 30-ны өдрийн 47

тоот тогтоолоор өвлийн улиралд буюу 12-р сарын 05-ны өдрөөс ирэх оны 2 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд төвийн бүх засмал замуудаар мотоцикльтой замын хөдөлгөөнд оролцохыг хориглосон байна.

Иргэдийн гомдлыг шуурхай шийдвэрлэх үүрэг өглөө

Аймгийн хэлтэс, албадын дарга нарын ээлжит шуурхай хуралдаанаар аймгийн Засаг дарга Г.Ганболд иргэдээс ирж байгаа санал гомдлуудыг түргэн шуурхай шийдвэрлэж байхыг дарга нарт үүрэг болголоо. Хуралдааны үеэр өнгөрөгч 7 хоногт Мэдээлэл шуурхай удирдлагын төвд иргэдээс ирсэн гомдол саналыг танилцууллаа. Иргэдээс тус төвд 20-нод гомдол санал иржээ.

Тухайлбал цас орсны дараа албан байгууллагууд, ААН-үүд ойр орчмын цаसाа цэвэрлэхгүй, холбогдох албанаас төвийн авто замууд болон уулзваруудаар давс цацахгүй байгаагаас халтиргаа, гулгаа үүсдэг талаар иргэд гомдолложээ. Мөн Арвайхээр сумын хэмжээнд мотоцикльтой иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэрийг сумын ИТХ, Цагдаагийн газраас гаргасан боловч ямар хугацаанд аль авто замуудаар зорчихгүй байх талаар мэдээллийг иргэдэд хүргээгүй, хөдөөнөөс орж ирсэн мотоцикльтой иргэдэд тухайн шийдвэрийг хэлэлгүйгээр журамлаж, торгож байна гэсэн гомдол ирсэн байна. Түүнчлэн хотын гэрэлтүүлэг, золбин ноход, БОЭТ-ийн ажил үйлчилгээ, Мэргэд сургуультай холбоотой гомдол саналууд иргэдээс ирснийг шуурхай хуралдаанаар хэлэлцлээ.

ХӨВСГӨЛ АЙМАГ



Засаг дарга "Тусгай олимп"-т оролцсон хүүхдүүдийг хүлээн авч уулзав

Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Ганболд "Тусгай олимп"-т амжилттай оролцсон хүүхдүүдийг хүлээн авч уулзан "Миний хувьд та бүхэнтэйгээ үргэлж хамт байна. Та бүхнийг дэмжин ажиллана" гэлээ. Хонгконг улсад 11-р сарын 24-29-ний өдрүүдэд болсон зүүн Азийн бүс нутгийн "Тусгай олимп"-т Хөвсгөл аймгаас С.Долгормаа ахлагчтай 3 хүүхэд оролцож бүгд медаль хүртжээ. Тодруулбал агаарын теннисний төрөлд оролцсон А.Баттөгс, Э.Энхбаяр нар

мөнгөн медаль, ширээний теннисний төрөлд оролцсон А.Дэлгэрмягмар хүрэл медаль тус тус хүртжээ. Тэмцээнд зүүн Азийн бүс нутгийн 6 орны 300 гаруй хүүхдүүд оролцсоноос анх удаагаа оролцож буй Хөвсгөлийн хүүхдүүд амжилттай оролцоод ирлээ. Өнгөрсөн 4 сард Хөвсгөл аймагт анх удаа "Тусгай олимп"-ийн тэмцээнийг зохион байгуулж 60 гаруй хүүхэд оролцож тэргүүн байрт шалгарсан хүүхдүүд Хонконгт болох тэмцээнд оролцох эрх авсан юм.

Ховор, нэн ховор ургамлын төлбөрийг нэмэв

Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар ховор, нэн ховор ашигт ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг нэмж тогтоов. Тус аймгийн хэмжээнд нэн ховор ургамал 39, ховор ургамал 95 төрөл, 120 зүйлийн элбэг ургамал ургадаг байна. Нэн ховор ургамлын төлбөрийн хэмжээ жилд 8000 төгрөг байсан бол 10000 төгрөг

болгож, ховор ургамлын үнэ 3500 төгрөг байсныг 6500 төгрөг болгож тус тус нэмэгдүүлэв. Төлбөрийг нэмэгдүүлэхдээ байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны А-282 тоот тушаалыг үндэслэн тогтоосон гэдгийг аймгийн БОАЖГ-ын дарга Р.Жаргалсайхан хэллээ.



ЭРЭН СУРВАЛЖЛАХ

ШҮҮХИЙН ТАНХИМААС

МАШ НУУЦАД ТООЦОГДСОН ДУУЛИАНТ ХЭРГИЙГ ӨНӨӨДӨР ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ШҮҮНЭ

Э.МӨНХ

Ардчиллын алтан хараацай А.С.Зоригийн амийг зэрлэгээр бүрэлгэсэн хэрэг 18 жилийн дараа нэг юм шүүхэд шилжсэн ч ШШГЕГ-ын 461 дүгээр хорих ангид эхэлсэн анхны шүүх хурлаар арванхоёрдугаар сарын 21-нийг хүртэл хойшлуулсан. Тэгвэл дуулиант хэргийг шүүх хурал өчигдөр дахиад л хаалттай эхэллээ. Учир нь хэрэгт маш нууц зэрэглэлтэй материал хавсрагдаж буй учраас олон нийтэд мэдэгдэж болохгүй, шүүх хурлын үеэр нууц мэдээлэл алдагдаж болзошгүй учраас бичлэг хийх хэрэгсэл, гар утсыг цагдаагийнхан хураан авсан юм. Эл хэрэгт сэжигтнээр татагдсан Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа, Т.Чимгээ нар шүүгдэж буй. Өнгөрсөн удаагийн шүүх хурлын дараа УИХ-ын гишүүн О.Баасанхүү Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зоригт хандан Шүүгдэгчдийн эрхийг хангуулах тухай албан тоот илгээж, шүүх хуралдааныг ШШГЕГ-ын харьяа хорих 461 дүгээр ангид хийж байгаа нь хууль зөрчиж байгаа тул дараагийн шүүх хурлыг зориулалтын шүүхийн байранд явуулж өгөхийг хүссэн ч шүүх хурлыг 461 дүгээр хорих ангид хийсэн. Шүүх хуралд Ерөнхий шүүгч М.Алдар даргалж, шүүгчээр Б.Мөнх-Эрдэнэ, С.Оюунчимэг нар оролцоно. Харин өмгөөлөгчөөр Л.Мөнхтөр, С.Оюунцэцэг, Д.Дашдорж, Л.Энхсайхан, улсын яллагчаар Б.Батжаргал, Ж.Сандагсүрэн нар оролцов.

Мөн шүүх хуралд хохирогчдын ар гэрийг төлөөлж Г.Чулуунбат гэрчээр оролцохоор болсон төдийгүй талийгаачийн гэргий Б.Булган ч гэрчээр оролцох тухай яригдаж байсан ч тэр ирээгүй юм. Харин шүүгдэгч Ц.Амгаланбаатарын ээж, Б.Содномдаржаагийн эгч шүүх хуралд оролцсон юм. Үүнээс гадна ОБЕГ-ын хоёр шинжээч оролцож байгаа талаар мэдээлсэн. Өглөөний 10:00 цагт эхэлсэн шүүх хурал үргэлжилсээр, 12:30 цагийн орчимд шүүх бүрэлдэхүүн нууцтай холбоотой асуудлаар хуралдаад эргэн хурлыг үргэлжлүүлсэн юм. Түүнчлэн шүүх хуралдаан эхлэхээс өмнө эмч нар ирсэн бөгөөд өмгөөлөгч С.Оюунцэцэгийн даралт ихэсээн учраас үзлэг хийсэн гэж тайлбарласан. Үүнээс хойш шүүх хурал завсарлаагүй бөгөөд улсын яллагч Б.Батжаргал,



Гэрэл зургийг Г.АРТҮҮЖИHN

Ж.Сандагсүрэн нар дөрвөн цагийн турш ялын дүгнэлтийг уншиж танилцуулсан байна. Хэдийгээр өмгөөлөгч нар шүүх хурлыг хойшлуулах хүсэлт

гаргасан ч шүүх бүрэлдэхүүн хүлээж аваагүй юм. Ингээд ялын дүгнэлтийг танилцуулсны дараа таван минут завсарлаад орсон. С.Зоригийг хөнөөсөн хэрэгт

сэжигтнээр Ц.Амгаланбаатар, Б.Содномдаржаа, Т.Чимгээ нараас 17:45 цагийн үед мэдүүлэг авч байв. Сэжигтнүүд мэдүүлэг өгсний дараа шүүх хурал завсарласан

юм. Хурлыг өнөөдөр Цагдан хорих 461 дүгээр ангид 10:00 цагт үргэлжлүүлэхээр болов. Дашрамд дурьдахад, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 234.2-т “Шүүх

хуралдааныг өдрийн цагаар, амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна” гэж заасны дагуу шүүх хуралдааныг завсарлуулсан ажээ.

ММ-ИЙН ТОДРУУЛГА

Ё.ЛХАГВАСҮРЭН: ЗӨВШӨӨРӨЛГҮЙ 19 АВТОМАТ ТОГЛООМЫН ГАЗАРТ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭЛЭЭ

Ж.МЯГМАР

Цагдаагийн байгууллагаас Улаанбаатар хотын хэмжээнд автомат тоглоомын төрийтэй тоглох, үйл ажиллагаа эрхэлж байсан аж ахуйн нэгжүүдийг шалгасан, 2016 оны арванхоёрдугаар сард архи согтууруулах ундаатай холбоотойгоор үйлдэгдсэн гэмт хэргэ, захиргааны зөрчлийн талаар тэдгээл хийлээ. Энэ үеэр Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төвийн ахлах тэрээжилтэн, цагдаагийн хошууч Ё.Лхагвасүрэнгээс зарим зүйлийг тодрууллаа.

Улаанбаатар хотын хэмжээнд автомат тоглоомын мөрийтэй тоглох болон үйл ажиллагаа эрхэлж байсан аж ахуйн нэгжүүдийг шалгасан гэлээ. Энэ талаар тодруулаач?

Хууль зүй дотоод хэргийн сайдын өгсөн үүргийн дагуу цагдаагийн байгууллагаас нийслэлд үйл ажиллагаа явуулдаг автомат тоглоомын газруудыг шалгалаа. Өнгөрөгч арваннэгдүгээр сарын 22-29-ний өдрүүдэд таван дүүргийн найман цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар шалгасан. Шалгалтаар хууль бусаар, тусгай зөвшөөрөлгүйгээр автомат тоглоомын үйл ажиллагаа явуулж байсан 25 газрыг шалгаж, харьяалах прокурорын зөвшөөрлөөр 19 газрын автомат тоглоомын 149 ширээ болон бусад эд зүйлийг хураан аваад байгаа.

Ийнхүү хууль бусаар мөрийтэй тоглоомын газар ажиглуулдаг газруудад ямар хариуцлага тооцдог юм бэ?

Шалгалтаар бусаар, тусгай зөвшөөрөлгүйгээр автомат тоглоомын үйл ажиллагаа явуулж байсан 16 хэрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 243 дугаар зүйлийн 243.1 хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн. Түүнчлэн гурван материалд эрүүгийн хэрэг үүсгэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн. Мөн тусгай зөвшөөрөлгүйгээр автомат тоглоом ажиллуулдаг зургаан газарт шалгалтын

ажиллагаа хийгдэж байгаа. Хариуцлагын тухайд, Эрүүгийн хуулийн 243 дугаар зүйл буюу Мөрийтэй тоглох хэсгийн 243.1-т хуулиар хориглосон мөрийтэй тоглоом /казино/ тоглосон, түүнийг зохион байгуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ гэж заасан байдаг.

Жил бүрийн өдийг албан байгууллагууд баяраа хийж эхэлдэг. Тиймээс ч хуурамч архи согтууруулах ундааны зүйл олширдог. Энэ дагуу ямар нэгэн аян зохион байгуулах уу?

Шинэ жилийн баяр дөхөж байгаагай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжүүд хамт олноороо шинэ жилийн баяраа тэмдэглэж эхлээд байгаа. Тиймээс бид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд шинэ оны баяр болохтой холбогдуулан нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг 4079 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлэн хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд 49 зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг аваад байна. Үүнээс насанд хүрээгүй

хүнд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн зөрчил долоо буюу 14.2 хувь, зохих зөвшөөрөлгүй болон гар дээрээс согтууруулах ундаа худалдан борлуулсан 23 зөрчил буюу 46.9 хувийг эзэлж байгаа. Энэ дашрамд дуулахад, баяр ёслолын үеэр иргэдийг архи, согтууруулах ундааг тохируулан хэрэглэх, гар дээрээс согтууруулах ундаа худалдан авахгүй байх, хамт олны баярын арга хэмжээг зохион байгуулахдаа ажилчдынхаа аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, албан байгууллагууд ажилчдадаа мэдээ, мэдээлэл өгч анхааруулах, архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас биеэ авч явах чадваргүй болсон нэгнээ харгалзах хүнгүй орхихгүй байх хэрэгтэй. Түүнчлэн биеэ авч явах чадваргүй болсон нэгнээ заавал ар гэрийнхэнд нь хүлээлгэн өгч, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхийг анхааруулж байна.

Шинэ жилээр иргэд хуурамч салот буюу пиротехникийн хэрэгсэлтэй болгоомжгүй харцаж, амь нас, эрүүл мэндээрээ хохирох тохиолдол цөөнгүй гардаг. Тэгвэл энэ талын хяналтыг хэрхэн тавих вэ?

Шинэ жилийн баяртай



холбогдуулан аж ахуйн нэгж байгууллага, иргэд ёслолын буудлагын гэрэлт хэрэгсэл буюу пиротехникийн хэрэгслийг худалдаж авдаг. Ёслолын буудлага хийх арга хэмжээнд оролцдог. Улаанбаатар хотын Цагдаагийн газраас “Пиротехникийн хэрэгсэл” нэгдсэн арга хэмжээг энэ сарын 15-аас эхлэн зохион байгуулж байгаа. Энэхүү арга хэмжээ маань “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хууль, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2009 оны 662 дугаар захирамж, НИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өрнөж байгаа. Тус арга хэмжээ ирэх нэгдүгээр сарын 01-ийг хүртэл үргэлжлэх юм.

Хууль бусаар энэ төрлийн бодисыг худалдаалсан аж ахуйн нэгж, байгууллагад ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Хууль бусаар энэ төрлийн бодис, хэрэгсэл худалдан борлуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага байвал шуурхай утсанд мэдээлэл өгөх боломжтой. Түүнчлэн шалгалтын баг хууль бусаар пиротехникийн хэрэгсэл оруулж ирдэг иргэн, аж ахуйн байгууллагад тогтмол хяналт шалгалт хийж байна. Хэрвээ шалгалтын явцад хууль бусаар оруулж ирж, худалдан борлуулж байгаа тохиолдол илэрвэл тухайн үед нь хуулийн хариуцлага хүлээлгэнэ. Бид пиротехникийн хэрэгслийг стандартын дагуу хэрэглэх, тусгай оператороор хийлгүүлэх, зөвшөөрлийн дагуу хийлгээр оруулж ирэх тал дээр илүү анхаарч хяналт тавьж ажиллаж байна. Харин зарим нэг байгууллагад энэ төрлийн бодистой зөв харьцах, стандартын дагуу оруулж ирэх, ёслолын буудлага хийхдээ заавал тусгай зөвшөөрөлтэй компанийг сонгон үйлчлүүлэх, оператороор буудлага хийлгэх шаардлага тавьсан.

STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

“March Madness”



Б.ДАВАА

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг 59 дэх удаагийн Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах наадмын “Спорт” төрөлд тэргүүн байр эзэлсэн бүтээлийг “Дэлхийн шилдэг гэрэл зураг” булангаараа хүргэж байна. Тус наадамд 128 орны 5775 зурагчин 82951 бүтээлээ ирүүлснээс энэ бүтээл оролцсон төрөлдөө манлайлж чаджээ. Өнгөрсөн оны гуравдугаар сарын 20-нд NCAA буюу Америкийн коллежийн сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж байсан бөгөөд

тухайн тэмцээний агшныг яг дээрээ нь гэрэл зургийн хальснаа буулгасан нь энэ аж. Зургийг АНУ-ын гэрэл зурагчин Грег Нелсон авсан байна. Омаха хотын Сенчериллинк сентерт Индиана, Вичита стэйтын эрэгтэй сагсанбөмбөгийн баг гал бутарсан тоглолт үзүүлж, Вичита 81-76 гэсэн харьцаагаар хоожжээ. Талбайд Рон Бакер, Ник Зейслофт, Ханнер Москюра-Переа, Рашард Келли нарын тамирчид тоглож байна. Тэмцээн хавар бүр зохион байгуулагддаг бөгөөд “March Madness” гэх нэрээр алдаршжээ. Түүнчлэн, 68 баг өрсөлддөг үндэсний хэмжээний томоохон тэмцээн юм байна.

ХӨЛБӨМБӨГ

Варди гурван тоглолтод оролцох эрхээ хасууллаа

“Лестер” клуб Вардигийн улаан хуудасны асуудлаар Английн хөлбөмбөгийн холбоонд гомдол гаргасан билээ. Премьер лигийн 17 дугаар тойрогт “Сток Сити”-тэй 2:2-оор тэнцсэн тоглолтын 28 дахь минутад Варди өрсөлдөгч багийн тоглогч Мама Дууфын хөл рүү жийж орсныхоо төлөө улаан хуудас авсан. Тоглолтын дараа “Лестер”-ийнхэн шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэж, Варди санаатай зөрчил гаргаагүй хэмээн давж заалдсан юм. Гэвч Английн хөлбөмбөгийн холбоо Вардигийн давж заалдсан гомдлыг авч хэлэлцсэнгүй. Ингэснээр Жейми Варди “Эвертон”, “Вест Хэм” болон “Мидлсбро” клубын эсрэг тоглолтыг өнжихөөр боллоо. Улмаар ирэх оны нэгдүгээр сарын 14-нд “Челси”-гийн эсрэг хийх тоглолтод эргэж ирэх нь.



Бидэнд тохиолдсон



Хүндхэн хөгтэй явдлууд

Myagmarsuren Erdenesuren



Дөрвөн жилийн өмнөх энэ өдөр дэлхий сөнөнө гээд л бүгд лаа, шүдэнз болж байлаа. Би ч төрөх дөхсөн байсныг хэлэх үү, үнэхээр сөнөх юм бол ядаж хүүхдээ харчихаад ээж болж үзчихээд үхье гээд л. Тэгсэн яг л арванхоёрдугаар сарын 20-ны шөнө өвдлөө шүү. Би ч эхлээд гүрийж байлаа. Бүр тэсэхээ байгаад хурдан

сөнөвөл гялс сөнөчихөөсэй гэж бодлоо. Сүүлдээ уйлаад амандаа үглээд л дэлхий сөнөөсэй гэж чин сэтгэлээсээ хүсч билээ. Тэгээд 21-ний өдөр миний бяцхан ханхүү мэндэлж, эмч нар шинэ эриний Чингис ирлээ гээд бөөн баяр болж байв. Өнөөдөр миний хүү дөрвөн нас хүрч байна. Дуулантай өдөр шуугиантай төрж билээ.

ДУУЛГАХ СОНИН



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ю.Цэдэнбал агсны мэндэлсний 100 жилийн ойн марк гарчээ

Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Маршал Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан маркийг Монгол Улсын Засгийн газрын захиалгаар хийж гүйцлээнд өчигдрөөс гаргалаа. Нээлтийн ажиллагаанд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, Ю.Цэдэнбалын дүү Ю.Жавзан, Юмжаагийн Цэдэнбалын Академийн тэргүүн дэд ерөнхийлөгч С.Галсан нар оролцсон юм. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, “Монгол Шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар нар анхны өдрийн дутуйг тамгалж гарын үсэг зурж баталгаажууллаа. 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоол, Ой тэмдэглэх тухай Засгийн газрын 333 дугаар тогтоолын хүрээнд Монголын үндэсний Төв музейд “Алдар гавьяаны замнал” үзэсгэлэн, Ц.Жамбалсүрэн “Монгол цэргийн нэрт зүтгэлтэн Маршал Ю.Цэдэнбал, Д.Төрбат “Маршалын нууц товчоон” ном гаргасан. Ю.Цэдэнбал агсны төрсөн газар Дурсгалын гэрэлт хөшөө босгосон, эрдэм шинжилгээний томоохон хурал зохион байгуулсан, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг Юмжаагийн Цэдэнбалын нэрэмжит болгосон зэрэг ажлыг зохион байгуулсан гэдгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хэлж байлаа.

“Приусны босс”-ууд асуй

Бүтэлгүй хоёр залуугийн нөхөрлөлийн талаар үзүүлдэг, хэзээ ч үзсэн үзэгчдийг удаадаггүй “Микроны босс” кинон хүн бүхэн санаж буй биз ээ. Тэгвэл тус киноны хоёрдугаар анги буюу “Приусны босс” уран сайхны кино ирэх нэгдүгээр сарын 13-нд нээлтээ хийхээр болжээ. “Милл” кино компанийн уг бүтээлд өмнөх ангид гол дүрд тоглосон жүжигчин Д.Баттөмөр

буюу Батаа, жүжигчин С.Батзориг буюу Ишчүү, реппер Жий буюу Т.Мөнх-Эрдэнэ нар дахин тоглож байгаа аж. Мөн МУСТА О.Долгор, Б.Батмаа, Ц.Цэрэнболд, Б.Болд нар тоглосон байна. Дашрамд дурьдахад, өнгөрөгч 2013 онд бүтээсэн “Микроны босс” инээдмийн уран сайхны кино нээлтээ хийсэн цагаасаа хойш 147 сая төгрөгийн ашиг олсон хэмээн шуугиан тариад байсан билээ.

Улаанбаатарт:

Маргааш
 Өдөр -12
 Шөнө -23
 Нөгөөдөр
 Өдөр -10
 Шөнө -21

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАР БАР ӨДӨР

Наран ургах шингэх: 08.40-17.02
 Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ



Тухайн өдөр бэр, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ал даргах, үйл буруутгах, лалд золгох зэрэг үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлээгдэх, нохой уливал үхсний сураг сонсох, хэрэг дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувиас олдох, бие татвал эцэг, эхэд туу. Хөл татвал хэрүүл, тэлцэл гарах туу ёр болой. Өдрийн сайн цаг нь хуулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.

Соко, Халиуна, Хулан, Тамираа, Анар нар 23-24 насны охидууд. Тэд огт санаандгүй байдлаар харанхуй хонгилд сэрэх болно. Хаана байгаага ч мэдэхгүй, гэнэн цайлган таван охины санаанд оромгүй, авралд хүрэх гэсэн хөгжилтэй аргууд нь аюул дагуулж байгааг хэн нь ч ухаарсангүй. Гэвч тэд бэрхшээлтэй асуудлынхаа өмнө сөрөн зогсож чадах болов уу...? Үйл явдал цааш үргэлжлэх тусам инээдэм адал явдлаар дүүрэн, таныг хэзээ ч уйдаахгүйг амлаж байна.

Харри Потер сургууль дээрээ нэгэн зохиол унших болно. Харин тэр зохиол нь 70 жилийн өмнөх шидэтнүүдийн талаар болон Нью Йорк хот дахь нууц бүлгэмийн Newt Scamander-ийн адал явдал өгүүлэгдэх болно.

100,000Т

Гаран уулсана 2016.12.25

50,000Т

Гаран уулсана 2016.12.28

30,000Т

Гаран уулсана 2016.12.25

ХОСЫН КАРТ 15,000

Гаран уулсана 2016.12.28